



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ХУВЬ ХҮНИЙ НУУЦ

ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЛИЙГ
ХАМГААЛАХ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛЖ БҮЙ
ЭРХ ЗҮЙН ОРЧИН БОЛОН ПРАКТИКИЙН
СУДАЛГАА

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2020 он

НАА 67.3
ДАА 340.009
Х-640

ХУВЬ ХҮНИЙ НУУЦ, ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БОЛОН ПРАКТИКИЙН СУДАЛГАА

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Энэхүү судалгааг Өмгөөллийн Номин энд Адвокатс ХХН хийж гүйцэтгэв.

СУДЛААЧИД:

- О. Номинчимэг
- Б. Түшигжаргал
- Б. Гал-Ариун
- Б. Лхагважаргал

© Нээлттэй Нийгэм Форум ба Өмгөөллийн Номин энд Адвокатс ХХН, 2020

Энэхүү тайланд туссан хөндлөнгийн дүгнэлт, үзэл бодол нь
Нээлттэй Нийгэм Форумын байр суурийг илэрхийлэхгүй болно.

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

ISBN 978-9919-9645-1-1

АГУУЛГА

ХУРААНГУЙ	4
НЭГ. УДИРТГАЛ	6
1.1 Сэдвийг судлах хэрэгцээ, шаардлага	6
1.2 Сэдвийн судлагдсан байдал	9
1.3 Судалгааны арга зүй	11
ХОЁР. СУДАЛГААНЫ ХЭСЭГ	12
2.1 Эрх зүйн орчин	12
2.1.1 Хувь хүний нууц, түүний тодорхойлолт	12
2.1.2 Хувь хүний нууц ба хувийн мэдээлэл	14
2.1.3 Хувь хүний нууцыг хамгаалах тухай зохицуулалт	16
2.2 Шүүхийн практик	18
2.2.1 Иргэний хэргийн шүүхийн практик	18
2.2.2 Эрүүгийн хэргийн шүүхийн практик	20
2.2.3 Дүгнэлт	24
2.3 Практикт хувь хүний нууц, нууцтай холбоотой мэдээллийг ашиглаж буй байдал	25
2.3.1 Хувь хүний нууцыг цуглуулах	25
2.3.1 Хувь хүний нууцыг хадгалах	27
2.3.3 Хувь хүний нууцыг хамгаалах	27
2.4 Олон улсын эрх зүйн зохицуулалт	28
2.4.1 Европын Холбооны “Өгөгдөл хамгаалах ерөнхий дүрэм” буюу GDPR-ийн зохицуулалт	29
2.4.2 Сингапур Улсын зохицуулалт	37
ГУРАВ. ҮР ДҮН	39
3.1 Дүгнэлт	39
3.2 Санал, зөвлөмж	39
НОМ ЗҮЙ	41
ХАВСРАЛТ	45

ХУРААНГУЙ

Хувийн нууцтай байх, түүнийгээ хуулиар хамгаалуулах эрх нь Монгол Улсын Үндсэн Хуульд тусгагдсан халдашгүй чөлөөтэй байх эрхийн бүрдэл хэсэг билээ. Энэхүү эрхийн цар хүрээ нь мэдээллийн технологийн эрин үед хувь хүний нууц мэдээлэлд төрөөс халдахгүй байх уламжлалт агуулгаасаа өргөжиж, хувийн өгөгдөл буюу мэдээллээ хамгаалуулах эрхийн агуулгыг мөн багтаах болсон.

Монгол Улсад уг харилцааг 1995 онд батлагдсан “Хувь хүний нууцын тухай хууль”-иар зохицуулж буй нь мэдээллийн технологийн хөгжил болон орчин үеийн шаардлагад нийцсэн хамгаалалтыг бий болгож чадаж буй эсэх нь эргэлзээ дагуулж байна. Иймд энэхүү судалгааны хүрээнд хувь хүний нууц, холбогдох мэдээллийг хамгаалах харилцааг зохицуулж буй Монгол Улсын болон олон улсын эрх зүйн зохицуулалт, шүүхийн практик болон хувийн хэвшлийн байгууллагууд хувь хүний мэдээллийг хэрхэн цуглуулж, хадгалж, хамгаалж буй байдлыг судалсан болно.

Судалгааны үр дүнг тоймлон авч үзвэл, дээрх харилцааг зохицуулж буй нарийвчилсан хууль болох Хувь хүний нууцын тухай хуульд хэд хэдэн шалгуураар хувь хүний нууцыг хязгаарлагдмал хүрээнд тодорхойлжээ. Тодруулбал, хувь хүний нууц нь заавал хуульд заасан мэдээлэл байх шаардлагатай. Мөн нууц мэдээллийг задруулснаар тухайн хүний “хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй” байх ёстой байна. Хэдийгээр бодитоор хохирол учирсан байхыг шаардахгүй ч, зөвхөн хохирол учирч болзошгүй байх нь хангалтгүй бөгөөд зайлшгүй илтэд хохирол учруулж болзошгүй гэсэн өндөр шалгуур хангасан байхаар хуульд тогтоожээ.

Ийнхүү хувь хүний нууцын тодорхойлолт нь хэтэрхий явцуу, өндөр шалгуур тогтоосон байгаа тул хувь хүн өөрийн нууц болон холбогдох мэдээллийг хангалттай хэмжээнд хамгаалуулах боломжгүй байна. Түүнчлэн, хуулийн уг хязгаарлагдмал тодорхойлолтын улмаас шүүхээс хувь хүний нууц мэдээллийн агуулгыг явцуу хүрээнд тайлбарлах, шүүгч нэмэлт шаардлага тодорхойлох зэрэг асуудал үүсэж байгаа нь ажиглагдаж байна. Жишээлбэл, хохирогчийн хувийн нууцыг задруулсан гэж үзэхийн тулд задруулсан мэдээлэл нь тухайн хүнийг шууд тодорхойлж болохуйц байх ёстой гэж шүүхээс шийдвэрлэсэн тохиолдол байгаа юм.

Мөн түүнчлэн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хүрээнд хувийн мэдээллийг хамгаалах зохицуулалт байхгүй байна. Технологийн хөгжлийн тусламжтайгаар аливаа хувь хүний мэдээллийг илгээх, цуглуулах ажиллагааг

алсын зайнаас, шуурхай хийх боломжтой болсон. Энэ нь нэг талаараа бизнесийн үйл ажиллагаанд шинэ боломж үүсгэж байгаа ч нөгөө талаараа хувь хүний нууц мэдээлэл болон хувийн мэдээлэлд бусад этгээд халдах, алдагдах эрсдэлийг бий болгож байна.

Дээрх эрсдэлийг хэрхэн зохицуулж буй олон улсын туршлагаас үзвэл, хувь хүний нууц мэдээллээс гадна хувийн мэдээллийг хуульд тодорхойлж, түүнийг цуглуулах, хадгалах, ашиглахтай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан байна. Хувийн мэдээлэл гэх ойлголт нь хувь хүний нууц мэдээллээс ялгаатай бөгөөд тухайн хүнийг тодорхойлж болохуйц мэдээлэл байх гэсэн үндсэн шинж чанартай, харьцангуй өргөн цар хүрээтэй ойлголт юм. Хувь хүний нэр, хаяг, регистрийн дугаар зэрэг эдгээр мэдээллийг хувийн хэвшлийн байгууллагууд хамгийн өргөнөөр цуглуулж, ашигладаг билээ. Иймд хувийн мэдээллийг тодорхойлж, түүнийг хамгаалах журмыг хуульчилж, одоогийн хууль тогтоомжийн хүрээнд орхигдоод буй харилцааг зохицуулах нэн шаардлагатай юм.

Судалгааны хүрээнд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй зарим хувийн хэвшлийн байгууллагуудаас авсан асуулгыг шинжлэхэд эдгээр байгууллага нь хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах, хамгаалах асуудалд харилцан адилгүй хандаж байв. Жишээлбэл, хэрэглэгчийн мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулах тохиолдолд зарим байгууллага урьдчилан зөвшөөрөл авдаг бол зарим нь бүртгүүлэх үед энэ талаар сануулж, зөвшөөрөл авсан байдаг тул дахин авдаггүй гэж хариулжээ. Гэтэл уг зөвшөөрөл нь ямар хэлбэртэй байх ёстойг зохицуулсан хууль байхгүй тул хэдий зөвшөөрөл авсан ч тэр нь зөвшөөрч буй этгээдийн хувьд ойлгомжтой, тодорхой илэрхийлэгдсэн эсэхийг тогтоох боломжгүй байна.

Мөн олон улсын хэмжээнд хувийн мэдээллийг хамгаалахтай холбоотой бусад шинэ асуудлууд буюу цахим тодорхойлогч, мартагдах эрх зэрэг ойлголтууд бий болсон боловч эдгээрийг Монгол Улсын хууль тогтоомжоор зохицуулаагүй тул дээрх харилцааны хүрээнд эрх зүйн хийдэл бий болж байна.

Иймд хувь хүний нууц, түүнд холбогдох мэдээллийг хамгаалах тухай Монгол Улсын өнөөгийн эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаа тул цаашид хууль тогтоомжийг улам боловсронгуй болгох шаардлагатай байна.


НЭГ. УДИРТГАЛ

1.1 Сэдвийг судлах хэрэгцээ, шаардлага

Техник технологийн хөгжил, интернэтийн өргөн хэрэглээг дагаад хувийн мэдээлэл, хувь хүний нууцыг хамгаалахтай холбогдох харилцааг зохицуулах эрх зүйн зохицуулалт өдрөөс өдөрт шинэчлэгдэн өөрчлөгдөж байгаа билээ. Ихэнх улс орон уг харилцааг зохицуулахдаа өөрийн орны онцлогт тохирсон өгөгдөл хамгаалах хууль, мэдээлэл хамгаалах тухай хууль зэрэг багц хуулиудыг баталж, мөрдүүлдэг. Харин Монгол Улсын хувьд хувь хүний нууц болон хувийн мэдээлэл цуглуулах, ашиглах, хамгаалах тухай эрх зүйн зохицуулалт хангалттай шинэчлэгдэж, зохих хүрээг хамарч чадаж байгаа эсэх нь эргэлзээтэй байна.

Хувь хүний нууцын тухай хуулиар хувь хүний нууцыг хамгаалахтай холбоотой харилцааг ерөнхийлөн зохицуулж байгаа боловч уг хууль нь нийт 9 зүйлтэй, 1995 оноос хойш зөвхөн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбоотой нэг өөрчлөлт, Зөрчлийн тухай хууль батлагдсантай холбоотой өөрчлөлт орсноос бусад нэмэлт, өөрчлөлт оролгүй нийт 25 жил өнгөрчээ. Төрийн байгууллага, банк болон банк бус санхүүгийн байгууллагад холбогдох зарим зохицуулалт бусад хуулиудад дурдагдсан боловч хувийн мэдээллийн нууцлалыг хамгаалах талаар нийтлэг үйлчлэх ерөнхий зохицуулалт одоогоор дутмаг байна. Ийнхүү хувь хүний нууц болон мэдээллийг хамгаалахтай холбоотой хууль, эрх зүйн зохицуулалт 1995 оноос хойш дорвитой өөрчлөгдөлгүй явсаар өнөөг хүрчээ.

ГРАФИК 1. ХУВЬ ХҮНИЙ НУУЦ БОЛОН МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТойгоор Монгол Улсад батлагдсан материаллаг хуулиуд болон хуулийн төслийн цаг хугацааны дараалал



Харилцаа холбооны зохицуулах хороо болон статистикийн мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээллийг үзэхэд Монгол Улсад гар утас, компьютер, интернэт хэрэглэгчдийн тоо 2016 оноос хойш жил тутамд тогтмол нэмэгдэж байгааг харж болно. Цахим хэрэглээнд иргэд нэвтрэх тусам хувь хүний мэдээлэл, түүний нууцлал, аюулгүй байдлын асуудал яригдана. Үүнтэй зэрэгцээд хууль, тогтоомжийн шинэчлэл нь технологийн хурд, хэрэглэгчдийн өсөлттэй нийцэхүйц хэмжээнд хийгдэж чадахгүй байна.

ГРАФИК 2. ҮҮРЭН ТЕЛЕФОНЫ БҮРТГЭЛТЭЙ ХЭРЭГЛЭГЧ БОЛОН ИНТЕРНЭТ
ХЭРЭГЛЭГЧИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ (ДАВХАРДСАН ТООГООР)



Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

Ялангуяа КОВИД-19 цар тахлын улмаас зөвхөн бизнесийн харилцаагаар тогтохгүй нийгмийн харилцаа, оюутан, сурагчдын хичээл хүртэл цахимаар явагдах шаардлагатай болсон. Энэхүү гэнэтийн шилжилтийн улмаас мэдээллийн аюулгүй байдал, ялангуяа цахим халдлага, гэмт хэргийн тоо 2020 онд огцом нэмэгдсэн байна. Цахим аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2018 онд 42, 2019 онд 57 бүртгэгдэж байсан бол 2020 оны зөвхөн эхний 9 сарын байдлаар 114 болж хоёр дахин нэмэгджээ¹.

Хувь хүний мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах нь нэг талаасаа тухайн мэдээллийн эзэн болох хувь хүний эрхийг хамгаалах асуудал боловч, нөгөө талаасаа бизнес эрхлэгчдийн эдийн засгийн ашиг сонирхлыг харгалзан үзэх зайлшгүй шаардлагатай учраас дээрх хоёр эрх ашгийн зохистой тэнцвэрийг олсон эрх зүйн зохицуулалт шаардлагатай. Дэлхий дахинд e-commerce буюу цахим үйлчилгээнд тулгуурласан эдийн засгийн харилцаа нь томоохон байр суурийг эзлэх болсон. Монгол Улсын хувьд ч мөн ялгаагүй энэ салбарын өсөлт эрчимжиж байгаа бөгөөд нийт худалдан авагчдын 25 орчим хувь нь цахимаар худалдан авалт хийдэг бөгөөд эдгээрийн 70 орчим хувь нь цахим банкны аппликейшн ашигладаг байна². Эдийн засгийн хамгийн өндөр өсөлттэй байгаа

¹ Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2020 оны эхний 9 сард бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ <http://police.gov.mn/a/5330>

² Privacyshield олон улсын байгууллагын судалгаа, "Mongolia – E-commerce" <https://www.privacyshield.gov/article?id=Mongolia-ECommerce>

салбаруудын нэг болох цахим эдийн засгийн үндсэн элемент болох хувийн мэдээллийн эргэлтийг ойлгомжгүй, хэтэрхий хатуу зохицуулах нь эргээд жижиг, дунд бизнес эрхлэгчдэд дарамт учруулах эрсдэлтэй. Иймд НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал зэрэг олон улсын байгууллагуудаас хувийн мэдээллийг хамгаалах асуудлыг уг харилцаанд оролцогчдын эрх ашгийг тэнцвэртэй байлгах тал дээр анхаарч зохицуулах нь зүйтэй гэж зөвлөсөн байдаг³.

Гэтэл Монгол Улсын хувьд цахим худалдаа, цахим зээлийн үйлчилгээ болон бусад үйлчилгээ, аж ахуйн эрхлэгч байгууллагууд хувь хүний мэдээллийг ихээр цуглуулж буй ч тус харилцаанд холбогдох нэгдсэн эрх зүйн зохицуулалт байхгүйн улмаас харилцан адилгүй журмыг байгууллагадаа батлан мөрдүүлж байна. Ийнхүү эдгээр байгууллагад хувь хүний нууц болон хувийн мэдээллийг хамгаалж буй арга, техник болон хамгаалах ерөнхий шаардлага тодорхойгүйн зэрэгцээ, хувь хүн өөрийн мэдээлэл болон нууцтай холбоотой ямар эрх, үүрэг эдлэх нь мөн хуульд зохицуулагдаагүй байна.

Иймээс дээрх асуудлын хүрээнд Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын онцлог болон практик орчныг судалж, холбогдох зөвлөмж санал боловсруулах зорилготойгоор энэхүү судалгааг хийж гүйцэтгэлээ.

1.2 Сэдвийн судлагдсан байдал

Хувь хүний нууц, нууцад холбогдох мэдээллийг хамгаалахтай холбогдуулан хувь хүний мэдээлэл цуглуулж, ашиглаж, аюулгүй байдлыг ханган хамгаалж буй практик болон эрх зүйн орчны талаар судалж нийтэд ил болсон нарийн, нэгдмэл судалгаа одоогоор байхгүй байна. Харин хувь хүний нууц гэдэг ойлголтод юу хамаарах талаар МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, доктор, дэд профессор О.Мөнхсайхан “Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан Үндсэн эрхийн хүрээг тодорхойлох нь” эрдэм шинжилгээний өгүүлэл (2016)⁴, Б.Хонгорзул “Монгол Улсын Үндсэн хууль дахь хувь хүний нууцын эрхийг өргөн утгаар тайлбарлах нь” бакалаврын судалгааны ажил⁵ (2016) зэрэг бүтээлүүд байна. Эдгээр бүтээлд хувь хүний нууцын эрхийн Үндсэн хуульд тусгагдсан хүрээг тодруулахыг зорьсон ба ердийн хуулиар хувь хүний нууцад холбогдох эрхийг явцуу тайлбарласанд шүүмжлэлтэй ханджээ.

³ Data protection regulations and international data flows: Implications for trade and development, UNCTAD-ийн судалгааны тайлан. 5 дахь тал, https://unctad.org/system/files/official-document/dtlstict2016d1_en.pdf

⁴ О.Мөнхсайхан “Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан Үндсэн эрхийн хүрээг тодорхойлох нь” эрдэм шинжилгээний өгүүлэл, Хүний эрх сэтгүүл 2016/01, <http://legaldata.mn/b/611>

⁵ Б.Хонгорзул “Монгол Улсын Үндсэн хууль дахь хувь хүний нууцын эрхийг өргөн утгаар тайлбарлах нь” бакалаврын судалгааны ажил, 2016 он, <http://legaldata.mn/b/147>

Мөн 2017 онд Глоб Интернешнл төвөөс “Монгол Улс – Хэвлэл мэдээллийн эрх зүй (Онлайн, оффлайн орчин дахь хувь хүний нууц ба цахим эрх)” сэдэвтэй сургалтын гарын авлага⁶ гаргасан бөгөөд тус гарын авлагад хувь хүний нууцын талаарх ойлголт болон үүнийг ямар стандартын хүрээнд хамгаалдаг талаар бусад улс орнуудын эрх зүйн зохицуулалтыг судалсан байна. Түүнчлэн, хувь хүний нууцтай байх эрх болон мэдээлэл авах эрхийн тэнцвэрийг хангах нь нэн чухал талаар мөн тусгажээ.

Цаашлаад мэдээлэл хамгаалах асуудалтай холбогдуулан 2018 онд Монголын хуульчдын холбооноос “Мэдээллийн аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал” хэлэлцүүлгийг зохион байгуулж холбогдох сэдвээр тухайн салбар, мэргэжлийн хүмүүс илтгэл хэлэлцүүлсэн байна. Эдгээр илтгэл дундаас нийтэд ил болсон нь хуульч, судлаач Л.Галбаатарын “Мэдээллийн аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалт”⁷ сэдэвт илтгэл байх бөгөөд түүнд Эрүүгийн эрх зүй дэх мэдээллийн аюулгүй байдалд холбогдох зохицуулалтыг тайлбарлан, танилцуулжээ.

Хувь хүний нууц болон хувь хүний мэдээллийг хамгаалахтай холбогдуулан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас 2015-2018 онд “Цахим мэдээллийн аюулгүй байдлын тухай” хуулийн төсөл болон “Өгөгдөл хамгаалах тухай” хуулийн төслийг боловсруулж байсан боловч эдгээр төсөл Улсын Их Хурал (цаашид “УИХ” гэх)-аар хэлэлцэгдэж, батлагдаагүй. Мөн 2016 онд УИХ-д “Мэдээллийн аюулгүй байдлын тухай” хуулийн төсөл⁸ хэлэлцэгдэж байсан боловч хуулийн төслийг татан авсан байдалтай байна.

Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 2018 онд “Нээлттэй өгөгдлийн бэлэн байдлын үнэлгээ”-г боловсруулж гаргасан байх бөгөөд тус үнэлгээнд хувь хүний өгөгдөл, мэдээллийг тодорхой зорилгоор ашиглах, хамгаалах

⁶ Глоб Интернешнл төв “Монгол Улс – хэвлэл хэвлэл мэдээллийн эрх зүй (Онлайн, оффлайн орчин дахь хувь хүний нууц ба цахим эрх)” сэдэвтэй сургалтын гарын авлага, 2017 он http://globeinter.org.mn/images/upld/Toby_manual_2017mon.pdf

⁷ Хуульч, судлаач Л.Галбаатар “Мэдээллийн аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалт” 2016 он <https://www.slideshare.net/galbaatar1/ss-62879383>

⁸ Хуулийн төслийн Үзэл баримтлалд “төрийн байгууллагуудын 84 хувь нь мэдээллийн аюулгүй байдалд хяналт тавьдаггүй, тэдгээрийн 83 хувь нь мэдээллийн аюулгүй байдлын стандартыг мэддэггүй, 17 хувь нь зохих хэмжээгээр мөрддөг бөгөөд 6 хувь нь бүрэн дүүрэн халдлага илрүүлэх системтэй, 78 хувь нь халдлага илрүүлэх системтэй ч хөгжүүлэлт хийдэггүй, 16 хувь нь огт хамгаалалтгүй” мөн “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны 20 хувь нь технологиос, 80 хувь нь тухайн байгууллага, хувь хүнээс хамаардаг нь судалгаагаар нотлогдсон” гэж дурдсан байна. <http://forum.parliament.mn/projects/95>

талаар нарийн зохицуулсан хууль тогтоомж байхгүй талаар дурдсан байна⁹. Мөн хувь хүний нууцыг хамгаалахтай холбоотой шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тохиолдол бага байдгаас энэ хуулийн хэрэгжилтийг үнэлэх боломжгүй, өгөгдлийг автоматаар боловсруулах, дамжуулах, түгээх харилцаанд хувийн нууцыг хамгаалдаг тогтолцоо, механизм байхгүй байна гэжээ.

Дээрх судлагдсан байдлаас үзвэл, Монгол Улсын хувьд хувийн мэдээллийг хамгаалах талаарх судалгаа хангалттай бус бөгөөд нэн ялангуяа хувийн хэвшлийн байгууллагад хувь хүний нууцыг хэрхэн хамгаалж буй, мөн энэ хамгаалалт нь хангалттай эсэх талаар үнэлж дүгнэж болохуйц судалгаа байхгүй байна.

1.3 Судалгааны арга зүй

Энэхүү судалгааны хүрээнд хувь хүний нууц, хувийн мэдээллийг хамгаалахтай холбоотой Монгол Улсын өнөөгийн эрх зүйн байдал, зохицуулалт, холбогдох эрх зүйн хэм хэмжээ, шүүхийн шийдвэрүүд болон хувь хүний мэдээллийг цуглуулдаг байгууллагуудын баримталж буй бодлогод дүн шинжилгээ хийх байдлаар уг асуудалтай холбоотой өнөөгийн эрх зүйн болон практик орчныг судална. Мөн түүнчлэн, үйл ажиллагааныхаа хүрээнд хувийн мэдээлэл цуглуулж, түүн дээр үндэслэн бизнесийн ажиллагаа явуулдаг технологи, цахим худалдаа, цахим зээлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудаас асуулга авах замаар байгууллагуудын дотоод зохицуулалтыг судаллаа.

Ийнхүү дотоодын эрх зүйн зохицуулалт болон практикийг судлахаас гадна олон улсын хэмжээнд мөрдөгдөж буй хувь хүний нууц, хувийн мэдээллийг хамгаалах зохицуулалтуудад дүн шинжилгээ хийж, дотоодын зохицуулалттай харьцуулан судална. Эцэст нь, эдгээрийн үндсэн дээр ерөнхий дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах зорилготой энэхүү судалгаа хийгдсэн болно.

⁹ Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар “Монгол Улсын Нээлттэй өгөгдлийн бэлэн байдлын үнэлгээ” судалгаа, УБ хот, 2018 он, 15 дах тал
http://www.smart.gov.mn/wp-content/uploads/2018/11/Mongolia_ODRA_report_Mon_2019.pdf

ХОЁР. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

2.1 Эрх зүйн орчин

2.1.1 Хувь хүний нууц, түүний тодорхойлолт

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй [...] Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж иргэний үндсэн эрхийг хуульчилсан байдаг. Энэ зохицуулалтаас үзвэл хувь хүний нууцтай байх, түүнийгээ хуулиар хамгаалуулах эрх нь “халдашгүй, чөлөөтэй байх” үндсэн эрхийн бүрдэл хэсэг бөгөөд¹⁰ хувь хүний нууцыг хуулиар хамгаалах шаардлагыг үндсэн хуульд ийнхүү тусгажээ.

Дээрх зохицуулалтад үндэслэн 1995 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр Хувь хүний нууцын тухай хууль (“ХХНТХ”) батлагдаж, мөн оныхоо 7 дугаар сарын 1-ний өдрөөс даган мөрдөгдөж эхэлсэн бөгөөд тус хууль нь хувь хүний нууцыг хамгаалахтай холбогдох харилцааг зохицуулж буй суурь эрх зүйн зохицуулалт юм. Уг хууль нь 9 зүйлээс бүрдэх бөгөөд хэрэгжиж эхэлснээс хойш 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдөр болон 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлтүүд оржээ.

Тус хуульд, “[х]увь хүний нууц гэж Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ” хэмээн тодорхойлсон бөгөөд хувь хүний нууцыг дараах 5 төрөлд ангилсан байна.

1.	Захидал харилцааны нууц	Захидал, цахилгаан, илгээмж, өргөдөл зэрэг шуудан холбооны хэрэгслээр бусад хүн, байгууллагатай солилцож буй мэдээ, баримт бичиг, биет зүйл
2.	Эрүүл мэндийн нууц	Тухайн хувь хүний бие эрхтний гажиг, нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчнөөр өвчилсөн тухай мэдээлэл

¹⁰ Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13-т заасан “халдашгүй байх эрх” нь гурван агуулгыг илэрхийлдэг бөгөөд үүний нэг нь хувийн нууц халдашгүй байх эрх байдаг талаар судлаач, доктор О.Мөнхсайхан өөрийн “Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан үндсэн эрхийн хүрээг тодорхойлох нь” эрдэм шинжилгээний өгүүлэлд дурдсан байна.

3. Хөрөнгийн нууц	Зөвхөн эд хөрөнгө, оюуны өмч, эрхийн эзэн, эсхүл түүний итгэмжлэгдсэн хүмүүс мэдэх, түүнчлэн эрх бүхий байгууллага албан тушаалтны албан үүргийнхээ дагуу олж мэдсэн мэдээ, баримт бичиг, тоо, гэрээ хэлцэл, биет зүйл
4. Гэр бүлийн нууц	Бусдад задруулбал тухайн хувь хүн, түүний гэр бүлийн гишүүдийн нэр төр, алдар хүнд, ашиг сонирхолд харшлах мэдээлэл
5. Хуулиар тогтоосон бусад нууц	Хувь хүн өөрийн архив, хадгаламж, тэмдэглэл, битүүмжлэл болон тэдгээрт хамаарах дүрс, дуу бичлэгийг нууцалж болно.

Ийнхүү дээрх зохицуулалтаас үзвэл хувь хүний нууц нь:

- (i) хуульд заасан байх;
- (ii) задруулбал тухайн хүний нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй байх болон
- (iii) мэдээ, баримт бичиг, биет зүйл байх шаардлагатай байна.

Үүнээс үндэслэн авч үзвэл, нэн тэргүүнд хувь хүний нууц нь зөвхөн хуульд заасан нууцаар хязгаарлагдсан байна. Хэдийгээр дээрх тодорхойлолтын дагуу аливаа нууц мэдээллийг задруулснаар тухайн хүнд бодит хохирол учирсан байхыг шаардахгүй байгаа ч “илтэд хохирол учруулж болзошгүй” гэж давхар тодорхойлсон нь ойлгомжгүй байгаа юм. “Хохирол учруулж болзошгүй”, “илтэд хохирол учруулж болзошгүй” гэсэн шалгуурууд нь магадлалын хувь хэмжээгээр ялгаатай бөгөөд илтэд гэсэн шалгуурыг нэмж тогтоосноор хохирол учруулж болзошгүй стандартыг дээшлүүлжээ. Өөрөөр хэлбэл, зөвхөн хохирол учруулах магадлалтай байх нь хангалтгүй бөгөөд үндэслэл бүхий хүн тухайн нөхцөл байдлыг хохирол учруулах нь тодорхой гэж дүгнэхүйц байх ёстой гэж ойлгохоор байна.

Харин хувийн нууцад хамаарах мэдээллийн хэлбэрийн хувьд мэдээ, баримт бичиг, биет зүйл байна гэж тодорхойлжээ. Эдгээрээс баримт бичиг, биет зүйлс нь бодитой оршин байх, өөрөөр хэлбэл гарт баригдахуйц юмс байх бол “мэдээ” гэсэн ойлголтыг хэрхэн тайлбарлахаас хамаарч эдгээрээс бусад мэдээлэл (бодитоор хөрвүүлээгүй цахим систем дээр хадгалагдсан зураг, бичлэг гэх мэт) хувийн нууцад хамаарах эсэхийг тодорхойлж болохоор байна.

ХХНТХ-ийн дээрх тодорхойлолтыг үзвэл, хувь хүний нууц гэдгийг хэлбэр, задарсан тохиолдолд учруулж болзошгүй хохирол, болон хуульд тусгайлан заасан байх гэсэн хэд хэдэн шалгуураар хязгаарлаж тодорхойлжээ. Гэхдээ хувь

хүний нууцыг ийнхүү хязгаарлагдмал хүрээнд тодорхойлсон нь практикт хувь хүний нууцыг хамгаалахад төвөгтэй нөхцөл байдлыг бий болгох эрсдэлтэй бөгөөд нийгмийн хурдацтай хөгжлийн үр дүнд хуулиар тодорхойлогдоогүй ч хувь хүний нууцад хамруулан хамгаалах шаардлагатай мэдээлэл бий болохыг үгүйсгэх аргагүй билээ. Өөрөөр хэлбэл, өнөөгийн зохицуулалтаар хуульд тусгайлан нэрлээгүй л бол хувь хүний нууцыг хамгаалах боломжгүй байгаа юм¹¹.

2.1.2 Хувь хүний нууц ба хувийн мэдээлэл

Бусад улс орон¹² дан ганц хувь хүний нууц гэлтгүй хувийн мэдээллийг мөн хуулиар зохицуулж, хамгаалсан байдаг. 2016 оны 5 дугаар сарын 24-ний өдөр батлагдаж, 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн Европын холбооны “Өгөгдөл хамгаалах ерөнхий дүрэм¹³” буюу GDPR (цаашид “GDPR” гэх)-т зааснаар хувийн мэдээлэл гэдэг нь хувь хүнийг тодорхойлох, эсхүл тодорхойлж болохуйц аливаа мэдээллийг хэлэх бөгөөд тухайн хувь хүнийг тодорхойлж болохуйц мэдээлэл гэдэгт нэр, дахин давтагдашгүй дугаар, байршлын мэдээлэл, цахим тодорхойлогч мэдээлэл, эсхүл тухайн хувь хүний бие махбод, физиологи, генетик, оюун санаа, эдийн засаг, соёл болон нийгмийн нөхцөл байдалтай холбоотой мэдээлэл багтдаг¹⁴.

Одоогийн байдлаар хувийн мэдээллийг хамгаалах тухай ойлголт Монгол Улсын хуулийн хүрээнд тодорхойлогдоогүй байна. Харин 2011 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь хэсэгт “сонгогчийн хувийн мэдээлэл” гэж тухайн иргэнийг гэрчлэх талаар хуульд заасан албан ёсны баримт бичигт туссан мэдээлэл, гэрэл зураг, биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг хэлнэ гээд сонгогч тус мэдээллээ авах эрхтэй байхаар зохицуулжээ. Гэвч энэхүү хууль нь зөвхөн сонгууль зохион байгуулж, дүнг гаргахад ашиглагдах тул уг тодорхойлолтыг ерөнхийлөн хэрэглэх боломжгүй юм.

Мөн 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д “иргэний үнэмлэхийн санах ой” гэж энэ хуульд заасны дагуу иргэний хувийн мэдээллийг агуулсан, мэдээлэл нь бичигдэх,

¹¹ Энэ талаар МУИС-ХЗС оюутан Б.Хонгорзулын “Монгол Улсын Үндсэн хууль дахь хувийн нууцын эрхийг өргөн утгаар тайлбарлах нь” бакалаврын судалгааны ажилд мөн дурджээ.

¹² Тухайлбал, Япон Улс нь “Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль”-аар “хувийн мэдээлэл” болон “онцгой хамгаалах шаардлагатай хувийн мэдээлэл” гэх ойлголтуудыг ялгаатай тодорхойлж, зохицуулжээ.

¹³ Европын холбооны “Өгөгдөл хамгаалах ерөнхий дүрэм” <https://gdpr-info.eu/>

¹⁴ Дэлгэрэнгүйг энэхүү судалгааны 8 дугаар хэсгээс үзнэ үү.

уншигдах, өөрчлөгдөх боломжтой цахим санах ойг хэлнэ гээд иргэний улсын бүртгэл хийхэд энэхүү мэдээллийг ашиглаж болохоор зохицуулжээ.


Дээрх хуулиудад тодорхойлсноос харахад, хувийн мэдээлэл гэдэгт иргэнийг гэрчлэх талаарх хуульд заасан албан ёсны баримт бичиг болон иргэний үнэмлэхэд тусгагдсан (i) мэдээлэл (ii) гэрэл зураг болон (iii) гарын хурууны хээг хамруулан ойлгохоор байгаа ч аль аль нь тусгай харилцааг зохицуулсан хуулийн зохицуулалт тул аж ахуй нэгжид хувийн мэдээллийг хамгаалах харилцаанд хэрэглэгдэх боломжгүй байна.

ХХНтХ дахь тодорхойлолтыг үзвэл, зарим хувийн мэдээллийг хувь хүний нууц гэж үзэх боломжтой ч бүхий л хувийн мэдээлэл нь хувь хүний нууцад хамаарахааргүй байна. Учир нь хувийн мэдээллийн гол шинж чанар нь тухайн хүнийг “тодорхойлох” боломжтой мэдээлэл гэдэгт оршдог. Гэтэл ХХНтХ-д заасан хүрээнд хамгаалагдахын тулд тухайн мэдээлэл нь задарсан тохиолдолд илтэд хохирол учруулахуйц байх ёстой гэсэн шаардлагыг хангах ёстой болдог. Жишээлбэл, тухайн хүний дахин давтагдашгүй дугаар буюу регистрийн дугаарыг ашиглан хувь хүнийг тодорхойлох бүрэн боломжтой. Гэвч регистрийн дугаарыг задруулснаар хувь хүний нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулах боломжтой гэж үзэхгүй тул ХХНтХ-иар хамгаалагдах мэдээлэл болохооргүй байна. Харин зарим шүүхийн шийдвэрүүдийг үзвэл, хувь хүний нууц гэдэгт тухайн хүнийг тодорхойлж болохуйц гэсэн шинж чанар хадгалагдаж байх шаардлагатай гэж үзэх хандлагатай байна¹⁵.

Иймд нэгэнт хувь хүний нууц мэдээлэл гэж үзэхийн тулд тухайн хүнийг тодорхойлох боломжтой байх шаардлагыг тавьж байгаа бол өнөөгийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд хувь хүний нууц гэж хамгаалагдах мэдээлэл нь хувийн мэдээллийн дотор багтах онцгой төрөл буюу түүнтэй төрөл, дүрсийн харилцаатай байна гэж дүгнэж болохоор байна.

¹⁵ Дэлгэрэнгүйг энэхүү судалгааны 6 дугаар хэсгээс үзнэ үү.

ГРАФИК 3. ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ БОЛОН ХУВЬ ХҮНИЙ НУУЦ
ХООРОНДЫН ХАМААРАЛ



2.1.3 Хувь хүний нууцыг хамгаалах тухай зохицуулалт

Өдгөө Монгол Улсад хувь хүний нууцыг хамгаалахтай холбоотой ерөнхий зохицуулалт ХХНТХ болон Байгууллагын нууцын тухай хуульд тус тус заасан байдаг хэдий ч энэхүү судалгааны 1.1 дэх хэсэгт дурдсанчлан эдгээр хуулийн зохицуулалт нь хязгаарлагдмал хүрээнд хувь хүний нууцыг тодорхойлж, уг нууцыг хэрхэн хамгаалах талаарх нарийн журмыг зохицуулж чадаагүй байна. Тухайлбал, ХХНТХ-ийн 5.1 дүгээр зүйлд хувь хүн нууцаа өөрөө хамгаална гэж заасан бөгөөд Байгууллагын нууцын тухай хуулийн 5.3 дугаар зүйлд “Байгууллага нь эрхэлж буй үйл ажиллагааныхаа дагуу олж мэдсэн хувь хүний нууцыг байгууллагын нууцын нэг адил хамгаална” гэж заасан байдаг. Үүнээс харвал, хувь хүн ХХНТХ-д заасан нууцаа өөрөө хамгаалах үүрэгтэй бөгөөд хэрэв үүнд хамаарах мэдээллийг аливаа байгууллагад өгсөн тохиолдолд уг нууцыг байгууллага хамгаалах ерөнхий үүрэгтэй байна.

Харин Байгууллагын нууцын тухай хуулийн 5.3 дугаар зүйлд заасны дагуу хувь хүний нууцыг олж авсан байгууллага уг мэдээллийг “байгууллагын нууцын нэг адил хамгаална” гэсэн нь нууцыг задруулахгүйгээр хамгаалах үүрэг үүсгэх үү, эсхүл өөрийн нууцыг хамгаалдагтай ижил арга хэмжээ авч хамгаалах үүрэг үүсгэх эсэх нь мөн тодорхойгүй байгаа юм. Хэрэв тухайн байгууллага өөрийн нууцыг хамгаалдагтай ижил түвшинд хувь хүний нууцад хамгаалалт олгох үүрэгтэй гэвэл хоёр үр дагавар гарах эрсдэлтэй. Үүнд: (i) байгууллагын нууцыг хамгаалах аливаа журам баталж, хэрэгжүүлдэггүй байгууллага хувь хүний нууцыг хамгаалах дорвитой арга хэмжээ авч чадахгүй; (ii) байгууллага өөрийн нууцыг хамгаалах өндөр шаардлага тогтоосон журамтай бол хувь хүний нууцыг түүнтэй ижил хамгаалах хатуу үүрэг байгууллагад үүсэхээр байна.

Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газар¹⁶, Цагдаагийн байгууллага¹⁷, Үндэсний статистикийн хороо, Архивын ерөнхий газар, Монгол банк¹⁸ зэрэг байгууллага нь мэдээллийн сантай байх, мэдээлэл хамгаалах талаар зохицуулалт, журамтай. Мөн төрийн байгууллагуудад байршиж байгаа цахим бүртгэл, мэдээллийн санг Үндэсний дата төвд шилжүүлэн байршуулах тухай Засгийн газрын 2012 оны 146 дугаар тогтоолыг¹⁹ мөрддөг учир хувийн хэвшлийн байгууллагатай харьцуулахад хувь хүний мэдээллийг хамгаалах талаарх эрх зүйн зохицуулалт тодорхой хэмжээгээр тусгагджээ.

Гэвч төрийн байгууллагаас хувь хүний үйл хөдлөлийг хянах зорилгоор цуглуулж буй мэдээллийг хэрхэн хамгаалж, ашиглах тухай эрх зүйн тусгайлсан зохицуулалт хангалттай эсэх нь эргэлзээтэй байна. Тодруулбал, Улаанбаатар хотын 2000 цэгт хүний нүүр царайг таних боломжтой ухаалаг камеруудыг суурилуулах “Аюулгүй хот” төслийг хэрэгжүүлэх болсныг нийслэлийн холбогдох албан тушаалтнууд мэдээлсэн²⁰. Гэтэл царай таних технологийг ашиглан цуглуулсан мэдээллийг хэн хянах, хэрхэн хамгаалах, ямар тохиолдолд ашиглах тухай нарийвчилсан зохицуулалт холбогдох хууль, журмуудад хангалттай тусгагдаагүй байна. Иймд уг төслийн хүрээнд царай таних технологийг ашиглахаас өмнө дээрх зохицуулалтыг тодорхой болгож хуульчлах зайлшгүй шаардлагатай.

Харин хувийн хэвшлийн байгууллагад холбогдох зохицуулалт нь зөвхөн банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо²¹-нд хамаарахаар байгаа юм. Иймд эдгээрээс бусад хувийн хэвшлийн байгууллагын нууц хамгаалах журмыг зохицуулсан нь үгүй байна. Өөрөөр хэлбэл, эдгээр байгууллага нууц хамгаалах журамтай байх ёстой эсэх, тухайн нууц хамгаалах журамд зохих ёсны шаардлага тавигдах эсэх нь тодорхойгүй байх бөгөөд хувь хүний нууцыг хэрхэн, ямар хүрээнд, ямар аргаар хамгаалах шаардлага нь харилцан адилгүй байж болохоор байна.

¹⁶ Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйл “Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан”, 2018 он

¹⁷ ХЗДХС-ийн 2017 оны А/195 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, шалгах, шинжлэн үнэлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх журам” https://police.gov.mn/resource/policegovmn/media/Khuuliin_Kheltes/195.pdf

¹⁸ Монгол банкны “Зээлийн мэдээллийн сан”-гийн мэдээлэл, <https://www.mongolbank.mn/ayan.aspx?id=03>

¹⁹ “Төрийн байгууллагын цахим мэдээллийн санг “Үндэсний дата төв”-д УГҮТ-т шилжүүлэн байршуулах тухай” Монгол Улсын Засгийн газрын 146 дугаар тогтоол, 2012 оны 12 дугаар сарын 1-ний өдөр.

²⁰ “Аюулгүй хот” төслийн тухай <https://ulaanbaatar.mn/Home/newsdetail?dataID=49191>

²¹ Зээлийн мэдээллийн тухай хууль, 2011 оны 10 дугаар сарын 20-ны өдөр.

Монгол Улсын Харилцаа холбооны тухай хуулийн 25.2.4-р зүйлд зааснаар харилцаа холбооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээд нь харилцаа холбооны сүлжээгээр дамжиж буй бүх төрлийн мэдээ, мэдээллийн нууцыг хадгалах, хамгаалах үүрэгтэй хэмээн заасан байдаг ч энд хувь хүнээс авсан мэдээлэлд хамаарах эсэх нь ойлгомжгүй, мөн хэрхэн хамгаалах талаарх нарийвчилсан зохицуулалтыг агуулаагүй байна. Үүнээс Монгол Улсад хувь хүний нууцыг цуглуулсан хувийн хэвшлийн зарим байгууллага ямар журмын хүрээнд хувь хүний нууцыг хамгаалах талаарх эрх зүйн зохицуулалт байхгүй гэсэн дүгнэлт хийж болохоор байгаа юм.

Харин хувь хүний нууцыг хадгалах асуудлын хувьд энгийн үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдүүд биш арилжааны банкнууд нь Монгол банкны Ерөнхийлөгчийн 2017 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн А-189 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Банкны мэдээллийн технологийн шалгуур үзүүлэлтийн журам”-д зааснаар мэдээлэл технологийн үндсэн болон нөөц төвүүд нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлах ёстой гэж зааснаас өөр зохицуулалт одоогоор байхгүй.

2.2 Шүүхийн практик

Энэ хэсэгт хувь хүний нууц болон хувийн мэдээлэлтэй хэрэг маргааныг шүүхэд хэрхэн шийдвэрлэж байгаа болон ямар төрлийн хэрэг илүү нийтлэг байдаг талаар өгүүлэх болно.

2.2.1 Иргэний хэргийн шүүхийн практик

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэгт “Хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай нотлох баримт нь төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой; ... тохиолдолд нотлох баримтыг хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүх бүрдүүлнэ” гэж заасан байх тул иргэний хэргийн шүүхэд хувь хүний нууцтай холбоотой нотлох баримт гаргуулах хүсэлттэй холбогдох маргаан нийтлэг ажиглагдав. Практикт талууд дараах төрлийн мэдээллийг нотлох баримтаар гаргуулахаар шүүхэд хүсэлт гаргасан байна.

- (i) Эмнэлгийн магадлангийн хянан шалгах комиссоос хүнд өвчтэй гэх тодорхойлолт гаргуулах²²

²² Дархан уул, Сэлэнгэ аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 1 дүгээр сарын 04-ний өдрийн магадлал дугаар 05 <http://shine.shuukh.mn/irgendavah/1368/view>

(ii) Нэхэмжлэгчийн өөрийн өвчний тухай эмнэлгийн оношилгоо²³

(iii) Дансны хуулга

(iv) Үл хөдлөх хөрөнгийг улсын бүртгэлд анх бүртгүүлэхэд бүрдүүлсэн материал гэх мэт.

Харин нотлох баримтыг үнэлэх асуудлын хувьд тухайн этгээдийн зөвшөөрөлгүйгээр дуу авианы, эсвэл дүрс бичлэг хийсэн тохиолдолд нотлох баримтыг цуглуулах журам зөрчсөн гэх үндэслэлээр нотлох баримтаар үнэлэхээс татгалзаж байгаа²⁴ нь шүүхээс хувь хүний нууцыг хамгаалж буй хэлбэр гэж үзэж болохоор байна.

Түүнчлэн, иргэн болон банк бус санхүүгийн байгууллагуудын хооронд байгуулсан “Зээлийн гэрээ”-тэй холбоотой маргаан цөөнгүй байх бөгөөд ихэнх тохиолдолд тухайн гэрээнд “Зээлдэгч гэрээнд заасан зөрчлийг гаргаж, гэрээг цуцалсан тохиолдолд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан зээлдэгчийн бизнесийн болон хувийн нэр төрд халдах” болон “гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зээлдэгчийн бизнесийн болон хувийн нэр хүндэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр халдана” гэх агуулга бүхий заалтуудыг талууд тохиролцсон байсныг шүүхээс ХХНТХ-ийн 4 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг (хөрөнгийн нууц)-ийг зөрчиж байна гэсэн үндэслэлээр хүчин төгөлдөр бус болгожээ²⁵.

Үүнээс гадна, банкны эсвэл төрийн байгууллагын ажилтан хэрэглэгчийн нууц болон мэдээлэлд үндэслэлгүйгээр нэвтэрсэн, бусдад дамжуулсан тохиолдолд тухайн ажилтныг ажлаас нь халсан, хариуцлага тооцсонтой холбогдох маргаан мөн цөөнгүй байна²⁶.

Гэвч өмнөх хэсэгт дурдсанчлан хувийн хэвшлийн зарим аж ахуйн нэгжид хувь хүний нууцыг хэрхэн хамгаалах болон хувийн мэдээллийн талаар хуулийн

²³ Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн магадлал дугаар 113 <http://shine.shuukh.mn/irgendavah/1290/view>

²⁴ Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 3908 дугаартай шийдвэрт дуу авианы бичлэг, харин 2016 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 3397 дугаартай шийдвэрт дүрс бичлэг нууцаар хийснийг нотлох баримтаар тус тус үнэлээгүй байна.

²⁵ Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 696 дугаар магадлал <http://shine.shuukh.mn/irgendavah/2137/view> болон Иргэний хэргийн хяналтын шатны шүүхийн 2017 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 130 дугаартай тогтоол <http://new.shuukh.mn/irgenhyanal/2164/view>

²⁶ Иргэний хэргийн хяналтын шатны шүүхийн 2014 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 157 дугаартай тогтоолоор Хаан банкны Төв аймаг дахь төв салбарын ажилтан хувийн ашиг сонирхлын үүднээс харилцагчийн зээлийн мэдээлэлтэй танилцсаныг ноцтой зөрчилд тооцон ажлаас халсан бөгөөд шүүхээс тус шийдвэр нь үндэслэлтэй гэж үзсэн байна. <http://www.shuukh.mn/irgenhyanal/17/view>

зохицуулалт байхгүйгээс үүнд холбогдох шүүхийн практик иргэний шүүхэд тогтоогүй байна.

2.2.2 Эрүүгийн хэргийн шүүхийн практик

2002 оны “Эрүүгийн хууль”-д “Иргэний захидал, харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчсөн бол”, “Хуулиар хамгаалагдсан хувь хүний нууцыг мэдсэн этгээд задруулсан бол”, мөн “Хувь хүний нууцыг олон нийтэд тараасны улмаас бусдад хүнд хор уршиг учирсан бол” эрүүгийн хариуцлага тооцохоор заасан. Тус зохицуулалтаас үзвэл, 2002 оны Эрүүгийн хуульд захидал, харилцааны нууцаас бусад хувь хүний нууцыг задруулах гэмт хэргийг материаллаг гэмт хэрэг байхаар зохицуулсан байсан бол 2015 оны “Эрүүгийн хууль”-аар хувь хүний нууцад холбогдох гэмт хэргийн агуулгыг дараах байдлаар өргөсгөжээ. Тодруулбал, “Хувь хүний нууцад халдах” болон “Хувь хүний нууцыг задруулах” гэх төрлийн гэмт хэргийг хуульчилсан байх бөгөөд аль аль нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй буюу үйлдэл хийснээр дуусах гэмт хэрэг байна.

Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрүүдийг судалж үзэхэд, Эрүүгийн хуулийн 13.11 дүгээр зүйлд заасан “хувь хүний нууцыг задруулах” гэмт хэрэг нь 13.10 дугаар зүйлийн “хувь хүний нууцад халдах” гэмт хэргээс нийтлэг байх бөгөөд аливаа байгууллагын ажилтан, албан тушаалтан өөрийн албан үүргээ гүйцэтгэж байх явцдаа хувийн ашиг сонирхлын үүднээс, аль эсхүл бусдын нэр хүндэд халдах зорилгоор үйлдэх нь элбэг байна.

Эрүүгийн шүүхийн зүгээс Эрүүгийн хуулийн “Хувь хүний нууцыг задруулах” гэмт хэргийг шийдвэрлэхэд “тухайн үйлдлийн зорилго” болон “хохирогчид илтэд хохирол учруулж болох эсэх” гэх нөхцөлд ач холбогдол өгөн шалгаж байгаа нь дараах хэргүүдээс харагдаж байна.

(А) ШҮҮГДЭГЧ С.А-д ХОЛБОГДОХ ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТУХАЙ

Холбогдох зүйл хэсэг

Эрүүгийн хуулийн 13.11.1 “Хувь хүний нууцыг задруулах”

Үйл баримт

Шүүгдэгч С.А нь 2016 оны орон нутгийн сонгуульд нэр дэвшсэн бөгөөд тухайн үед түүний фейсбүүк хаяг руу нэгэн нууц хаягаас Увс аймгийн иргэн Ц.Ц-д холбогдох 2 хуудас материал ирүүлжээ. Тодруулбал, С.А-тэй нэг хэсэгт нэр дэвшигч Ч.Ч-ийн эхнэр нь Увс аймгийн нэгдсэн төрөх эмэгтэйчүүдийн эмнэлгийн удирдлагаар ажилладаг бөгөөд хохирогч Ц.Ц нь тус эмнэлэгт үр хөндүүлж, эрүүл мэндээрээ хохирсон

талаарх мэдээлэл байжээ. С.А-ийн хувьд тухайн үедээ уг мэдээллийг задруулалгүй орхисон боловч Ч.Ч нь 2019 оны 5 дугаар сарын 28-ны өдөр жагсаал цуглаан зохион байгуулж жагсаал дээрээ С.А-ийг “ялтан заазуурчин” гэх мэтээр хэлж, түүний нэр хүндэд халдсан байна. Ингээд С.А нь дээрх 2 хуудас материалыг 2019 оны 5 дугаар сарын 28-ны өдөр Увс аймгийн цахим сүлжээ болох “Увсад тавтай морил” фейсбүүк хаягт өөрийн С-ийн А гэх фейсбүүк хаягаас тавьж, Ц.Ц-ийн эрүүл мэндийн нууцын мэдээллийг түүний зөвшөөрөлгүйгээр задруулжээ.

Анхан шатны шүүхийн шийдвэр²⁷

С.А-г гэм буруугүй гэж үзэн цагаатгах тогтоол гаргасан.

Үндэслэл

Хувь хүний нууц гэдэг нь Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ. Хувь хүний нууцыг задруулах гэдэг нь тухайлсан хүний хувийн нууцыг агуулсан мэдээ сэлт, бичиг баримт, зураг бичлэг, бусад биет зүйлсийг хөндлөнгийн хүмүүст санаатай тараасан байхыг ойлгоно. Гэтэл шүүгдэгч С.А-ийн нийтэлсэн мэдээлэх маягт нь хохирогч Ц.Ц-ын хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй гэх шинжийг агуулаагүй, хохирогч Ц.Ц-ийн нууц гэдгийг хөндлөнгийн хүмүүс мэдээгүй байна.

Хэдийгээр хувь хүний нууцыг задруулах гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг боловч задруулсан үйлдэл нь хохирогчийн хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд хохирол, хор уршиг учруулж болзошгүй шинжийг агуулсан эсэхээс хамаарч нийгэмд аюултай үйлдэл эсэх нь тодорхойлогдоно. Гэтэл энэ нөхцөлд С.А-ийн гэм буруугийн санаатай хэлбэр үгүйсгэгдэж байна. Учир нь тэрээр маягтын 2 ширхэг зургийг нийтлэхдээ хохирогчийн эцгийн нэр, регистрийн дугаар зэргийг нууцалж тавьсан нь хохирогчийн нууцыг задруулах зорилгогүй, зөвхөн хууль бус үр хөндөлтийн талаар мэдээлэх зорилготой байсан тул гэм буруугүй гэж үзсэн байна.

²⁷ Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 90 дүгээр цагаатгах тогтоол <http://new.shuukh.mn/eruanhan/45700/view>

(Б) ШҮҮГДЭГЧ Н.М-Т ХОЛБОГДОХ ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТУХАЙ

Холбогдох зүйл хэсэг

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг

Үйл баримт

Н.М нь Нийгмийн даатгалын ерөнхий газарт ажилладаг бөгөөд “Монголын цахилгаан холбоо” ХК-иас Нийгмийн даатгалын ерөнхий газарт ирүүлсэн 3 удаагийн албан бичгийн дагуу хохирогч П.Б-ийн эрүүл мэндийн нууц болох мэдээллийг (Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын акт) өгсөн байна. Тус актад П.Б нь хөдөлмөрийн чадвар алдагдалтай хэмээн тодорхойлогдсон байсан бөгөөд энэ мэдээлэлд үндэслэн эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй гэх шалтгаанаар ажлаас нь халжээ.

Шүүгдэгч Н.М-ийн зүгээс “П.Б нь 2015 онд Дархан-Уул аймгийн Цахилгаан холбооны газар ажилд орохдоо хөдөлмөрийн чадвар алдалттай гэдгээ мэдэгдэх үүрэгтэй байсан ч мэдэгдээгүй. Тухайн мэдээллийг ажил олгогч нь ашиглаад П.Б-ийн эрх зүйн байдалд халдаж, ажил хөдөлмөрөөс нь халах юм байна гэж мэдээгүй гэж мэдүүлжээ. Харин хохирогч П.Б нь “Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиар хэн нэгэн ажилд орохдоо ажил олгогчдоо өөрийн өвчний талаар мэдээлэх үүрэг байхгүй. Энэ бол урьдчилан зохион байгуулсан хэрэг. Намайг удаа дараа ажлаас халах гэж оролдсон. Харин шүүгдэгч Н.М бол энэ хэргийн золиос, түүнээс нэхэмжлэх зүйл байхгүй” гэжээ.

Анхан шатны шүүхийн шийдвэр²⁸

Гэмт хэргийн шинжгүй гэж үзсэн.

Үндэслэл

Хувь хүний нууцыг задруулах гэдэг нь хүний хувийн нууцыг агуулсан мэдээ сэлт, бичиг баримт, зураг бичлэг, бусад биет зүйлийг хөндлөнгийн хүмүүст санаатай тараасан байхыг ойлгоно. Шүүгдэгч Н.М-ын хувьд дээрх хэргийг гэм буруугийн санаатай хэлбэрээр, зориуд хүсэж үйлдсэн гэж үзэх нөхцөл байдал тогтоогдохгүй байна.

Мөн Хохирогч П.Б-ийн E10 инсулинээс хамаарах чихрийн шижин өвчин нь ердийн өвчинд тооцогдох бөгөөд ажил олгогчийн хүсэлтийн дагуу салбарын ажилтны хөдөлмөрийн чадвар алдалтын талаарх эрүүл

²⁸ Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 59 дугаар шийдвэр <http://new.shuukh.mn/eruaanhan/40244/view>

мэндийн мэдээллийг албан бичгээр хүргүүлсэн шүүгдэгчийн үйлдлийг хохирогчийн хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулсан гэж үзэх боломжгүй.

Давж заалдах шатны шүүхийн магадлал²⁹

Анхан шатны шийдвэр үндэслэлтэй

Үндэслэл

Хувь хүний нууцыг задруулахад ямар нэг тодорхой зорилгыг агуулсан байх ёстой боловч тус зорилго Н.М-ийн үйлдэлд тогтоогдохгүй байна.

Хяналтын шатны шүүхийн тогтоол³⁰

2015 оны Эрүүгийн хуульд заасан “хувь хүний нууцыг задруулах” гэдгийг хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг олж мэдсэн хүн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр задруулсан гэж ойлгох бөгөөд ХХНТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.2-т “Эрүүл мэндийн нууцад тухайн хувь хүний бие эрхтний гажиг, нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчнөөр өвчилсөн тухай мэдээллийг” ойлгохоор заасан. П.Б-ийн чихрийн шижин нь “халдварт өвчнөөс бусад өвчин” гэдэгт эргэлзээгүйгээр хамаарч байна.

Хэдий Н.М нь бусдын зөвшөөрөлгүйгээр хувь хүний нууцыг ажил олгогч байгууллагад хүргүүлсэн нь хууль, журмаар тогтоосон зөвшөөрлийн тогтолцоог үгүйсгэж, эрх зүйн хэм хэмжээнд харшилсан үйлдэл мөн боловч эрүүгийн гэмт хэргийн үндсэн шинж болох нийгмийн хор аюул, бодитой учирсан хор хохирол үгүйсгэгдэж байх тул гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан гэж үзэж гэмт хэрэгт тооцохоос татгалзав. Хэдий тийм ч хууль ёсны дагуу явагдсан ажиллагаа гэж үзэхгүй тул Эрүүгийн хуулиас бусад хууль тогтоомжоор хариуцлага хүлээлгэх нь шударга ёсны зарчимд нийцнэ гэж шийдвэрлэжээ.

²⁹ Дархан-Уул аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 39 дүгээр магадлал <http://new.shuukh.mn/eruudavah/9910/view>

³⁰ Улсын дээд шүүхийн 2020 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 435 дугаар тогтоол <http://new.shuukh.mn/eruuhyanal/2475/view>

Дээрх шийдвэрүүдээс “Хувь хүний нууцыг задруулах” гэмт хэрэг гэж тооцогдохын тулд “тухайн үйлдлийг хийсэн зорилго” болон “хохилогчид илтэд хохирол учрахаар байсан” гэх урьдчилсан нөхцөлүүд хангагдах ёстой³¹ байна. Энэ нь тус судалгааны ажлын 1.1 дэх хэсэгт дурдсаны дагуу “хувь хүний нууц” гэх ойлголт хуульд хэт явцуу байдлаар тодорхойлогдсонтой мөн холбоотой бөгөөд үүний сөрөг үр дагавар гэж үзэж болохоор байна.

Гэвч хувийн хэвшлийн байгууллагад хувь хүний нууц болон мэдээллийг ашиглах, хамгаалах, хадгалах талаарх нарийвчилсан зохицуулалт болон хариуцлага тооцох механизм байхгүй тул үүнд холбогдох гэмт хэргийн шүүхийн практик тодорхойгүй байна.

2.2.3 Дүгнэлт


Өмнө дурдсанчлан, зарим хувийн хэвшлийн байгууллагад хувь хүний нууцыг хамгаалах талаар болон хувь хүн өөрийн нууц, мэдээлэлтэй холбогдуулан хэрэгжүүлэх эрхийг хуульд нарийн заагаагүй тул иргэний болон эрүүгийн хэргийн шүүхэд энэ харилцаанд холбогдох маргаан цөөн байна. Хувь хүний нууцыг задруулсан тохиолдолд тухайн ажилтныг халах, хариуцлага тооцох, мөн холбогдох гэрээний нөхцөлийг хүчингүй болгох зэрэг шийдвэрийг Иргэний шүүхээс гаргаж байгаа бол Эрүүгийн шүүхийн хувьд тус үйлдлийг гэмт хэрэгт тооцоход хэт өндөр шаардлага тавьж байгаа байдал ажиглагдлаа. Харин аль ч тохиолдолд шүүхээс иргэн өөрийн нууцтай холбоотой ямар эрхийг хэрэгжүүлэх боломжтой талаарх тайлбарыг шийдвэртээ тусгаагүй байна.

³¹ Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 239 дугаар тогтоол <http://new.shuukh.mn/eruuhyanal/2420/view>
Шүүгдэгч С.Б нь Төрийн банкны салбарт мэдээлэл судалгааны эдийн засагчаар ажиллаж байхдаа Монгол банкны зээлийн мэдээллийн сангаас хохирогч харилцагчийн зээлийн данстай холбоотой мэдээллийг хууль бусаар олж авч, бусдад дамжуулсан үйлдэлд эрүүгийн хариуцлага тооцсон магадлалыг Улсын Дээд шүүхээс ямар санаа зорилгын хүрээнд, хэний эрх ашигт нийцүүлэн хийсэн болохыг тогтоогоогүй байна гэх үндэслэлээр прокурорт буцаасан байна.

2.3 Практикт хувь хүний нууц, нууцтай холбоотой мэдээллийг ашиглаж буй байдал

Бид энэхүү судалгааны явцад нийт 7 байгууллагаас тодорхой асуулгаар судалгаа авсан бөгөөд эдгээр 7 байгууллага бүгд хувь хүний нууцыг хамгаалах талаар байгууллагын нэгдсэн, бодлого журамтай хэмээн хариулжээ (График 4-ийг харна уу).

ГРАФИК 4. ХЭРЭГЛЭГЧИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ ТАЛААР БАЙГУУЛЛАГЫН НЭГДСЭН БОДЛОГО, ЖУРАМТАЙ ЭСЭХ




Харин дээр дурдсанчлан Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоор байгууллагын нууц хамгаалах журам нь ямар шаардлагад нийцсэн, ямар зохицуулалт агуулсан байх талаар эрх зүйн зохицуулалт огт байхгүй тул эдгээр байгууллагын дотоод журмын дагуу хувь хүний нууц зохих ёсоор хамгаалагдах эсэх нь эргэлзээтэй юм.

2.3.1 Хувь хүний нууцыг цуглуулах

Судалгаанд хамрагдсан байгууллагууд бүгд хэрэглэгчийн нэр, утасны дугаар болон цахим (и-мэйл) хаягийг авдаг хэмээн хариулсан байв. Дэлгэрэнгүйг График 5-аас харна уу.

ГРАФИК 5. ТАНАЙ БАЙГУУЛЛАГА ӨӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД
ХЭРЭГЛЭГЧДИЙН ЯМАР ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ АВДАГ ВЭ?



Дээрх байгууллагуудад цугларч буй бүх мэдээлэл нь ХХНТХ-д заасан “хувь хүний нууц” гэх ойлголтод бус 1.1 хэсэгт дурдсан “хувийн мэдээлэл”-д илүү хамаарахаар байх боловч энэ талаарх эрх зүйн зохицуулалт, тодорхойлолт байхгүй тул эдгээр мэдээллийг цуглуулах эсэх тухай журам тодорхойгүй байдаг.

Бүх байгууллагын хувьд дээрх мэдээллийг шинэ хэрэглэгчээр бүртгэхэд болон үйлчилгээ сайжруулах, шинэ бүтээгдэхүүн санал болгох зорилгоор ашигладаг бөгөөд тал хувь нь хөнгөлөлтийн карт олгох, хүргэлтийн үйлчилгээ үзүүлэх болон үйлчилгээний шалгуур хангасан эсэхийг тогтоох зорилгоор цуглуулдаг гэжээ.

2.3.1 Хувь хүний нууцыг хадгалах

Бидний судалгааны асуулгад оролцсон 7 байгууллага хэрэглэгчийн мэдээллийг цаасар, өөрийн сервер дээр, гуравдагч этгээдийн Монгол Улс дахь сервер дээр болон гуравдагч этгээдийн гадаад улс дахь серверүүд зэрэгт хадгалдаг гэж хариулжээ (График 6-г харна уу).

ГРАФИК 6. ХЭРЭГЛЭГЧИЙН МЭДЭЭЛЛИЙГ ЯМАР ХЭЛБЭРЭЭР ХАДГАЛДАГ ВЭ?



Энэ тохиолдолд дээр дурдсанчлан Монгол Улсад хувь хүний нууцыг хэрхэн хамгаалах талаарх эрх зүйн зохицуулалт огт байхгүй тул хэрэглэгчийн хувийн мэдээллийг гадаад улсын серверт хадгалж болох эсэх, өөрийн сервер дээр хадгалж буй тухайн байгууллагын сервер болон гуравдагч этгээдийн сервер нь ямар шаардлага хангасан байх ёстой, гуравдагч этгээдийн серверт тухайн байгууллага нь хяналт тогтоож болох эсэх зэрэг нь зохицуулалтгүй байгаа тул хувь хүний мэдээллийг авсан байгууллагууд тухайн мэдээллээ зохих ёсоор хадгалж байгаа эсэх нь ч тодорхойгүй байгаа юм.

Харин хэрэглэгчийн зүгээс хүсэлт тавин тус мэдээллийг устгуулах боломжтой эсэх тал дээр судалгаанд хамрагдсан 7 байгууллагын 3 нь тийм, харин 4 нь үгүй гэж хариулсан боловч үгүй гэж хариулсан байгууллагуудын хувьд хуулийн дагуу хэрэглэгчийн мэдээллийг 5 хүртэл жил хадгалах үүрэг хүлээдгээ илэрхийлжээ.

2.3.3 Хувь хүний нууцыг хамгаалах

Судалгаанд хамрагдсан байгууллагуудын 4 нь хэрэглэгчийн мэдээллийг гуравдагч этгээдэд шилжүүлдэг бөгөөд ийнхүү шилжүүлэхдээ 2 байгууллагын хувьд “үйлчилгээний нөхцөлд урьдчилан тусгасан байдаг тул хэрэглэгчдэд мэдэгддэггүй мөн зөвшөөрөл авдаггүй”, харин нэг байгууллага нь “хэрэглэгчээс тусгайлан зөвшөөрөл авдаг”, үлдсэн нэг байгууллага нь “мэдээллийг шилжүүлэхдээ хэрэглэгчдэд мэдэгддэг” гэж хариулжээ. Ийнхүү нэгдсэн журам байхгүйгээс хэрэглэгчийн мэдээллийг гуравдагч этгээдэд шилжүүлэх стандарт

тодорхойгүй болж өөр өөр практик бий болсон байх тул ямарваа хэрэг маргаан гарсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй байгаа юм.

Ийнхүү гуравдагч этгээдэд хэрэглэгчийн мэдээллийг шилжүүлдэг байгууллагууд нь тухайн гуравдагч этгээдээс өөрийн байгууллагын дотоодод мөрдөгддөг журмыг мөн адил дагаж мөрдөхийг шаарддаг ажээ.

2.4 Олон улсын эрх зүйн зохицуулалт

НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (цаашид “ХХБХ” гэх)-аас хувийн мэдээллийг хамгаалахтай холбоотой ахиц дэвшил гаргасан ч өнөөг хүртэл дэлхийн нийт улс орны гуравны нэгд нь хувь хүний мэдээллийг хамгаалах эрх зүйн орчин хангалттай биш байна³² гэсэн судалгааны үр дүнг 2020 оны 4 дүгээр сард мэдээлсэн байна. Хөгжиж буй орнуудын хувьд дөнгөж 63 орчим хувь, харин Ази, Номхон далайн бүсийн орнуудын 57 орчим хувь нь ямар нэгэн байдлаар хувь хүний мэдээллийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна гэжээ. Ялангуяа КОВИД-19 цар тахлын улмаас дэлхий дахин улам цахимжиж байгаа ч, түүнтэй зэрэгцэн цахим халдлагууд их гарах болсныг мөн ХХБХ-ийн уг тайланд дурджээ.

Харин Европын Комисс 2020 онд Европын Холбооны “Өгөгдөл хамгаалах ерөнхий дүрэм” буюу GDPR гарч болох өөрчлөлтүүдийг дурдахдаа технологийн тэргүүлэх компаниуд болох Гүүгл, Фейсбүүк, Ватсапп зэрэг компаниудын гаргасан зөрчлийг торгох торгуулийн хэмжээ хангалтгүй байгааг өөрчлөх чиглэлтэй байгааг дурдсан байна. Мөн түүнчлэн, Европын Холбооны зарим улсууд буюу Грек, Португал, Словени улсууд өнөөг хүртэл дотоодынхоо хувийн мэдээллийг хамгаалах хуулийг GDPR-т нийцүүлэн өөрчилж, батлаагүй байгааг түргэвчлүүлэх арга хэмжээ авах шаардлагатайг дурджээ³³.

Дээрхээс харвал, НҮБ болон Европын Холбоо зэрэг дэлхий даяар томоохон нөлөө бүхий байгууллагууд хувь хүний нууц, ялангуяа хувийн мэдээллийг хамгаалах асуудлыг чухалчлан хөндөх болсон бөгөөд олон улс орон хувийн мэдээллийг хамгаалах эрх зүйн хамгаалалт, зохистой орчныг бий болгох эрмэлзэл бий болсныг харж болно.

Иймд судалгааны энэхүү дэд хэсэгт хувийн мэдээллийг хамгаалах олон улсын жишиг гэгддэг GDPR-ийн зохицуулалт, мөн Сингапур Улсын хувийн мэдээллийг хамгаалах эрх зүйн ерөнхий зохицуулалтыг судаллаа.

³² Data and privacy unprotected in one third of countries, despite progress. <https://unctad.org/news/data-and-privacy-unprotected-one-third-countries-despite-progress>

³³ 2020 онд GDPR-т гарч болох өөрчлөлтүүд, <https://gdpr.eu/gdpr-in-2020/>

2.4.1 Европын Холбооны “Өгөгдөл хамгаалах ерөнхий дүрэм” буюу GDPR-ийн зохицуулалт

GDPR нь 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Европын Холбооны хувийн мэдээллийг хамгаалах эрх зүйн хэм хэмжээний акт юм. GDPR нь цахим орчинд хувь хүний мэдээллийг цуглуулах, ашиглах, хамгаалахтай холбогдох харилцаанд тухайн хувийн мэдээллээ өгч буй хувь хүнд илүү хяналт олгох зорилготой бөгөөд хувийн мэдээлэл цуглуулж буй этгээдүүдэд тодорхой шаардлага тавьж, цуглуулсан мэдээллийг зохистой хамгаалах идэвхтэй арга хэмжээ авах үүрэг тогтоосон байдаг.

(A) GDPR-ИЙН ҮЙЛЧЛЭХ ЦАР ХҮРЭЭ

GDPR-ийн чухал онцлогуудын нэг нь түүний үйлчлэх цар хүрээний хэмжээ юм. GDPR-ийн 3 дугаар зүйлд түүний цар хүрээ, чухам ямар этгээдүүдийн эрхийг хамгаалах тухай тодорхойлсон байдаг. Европын Холбооны Хувийн Мэдээллийг Хамгаалах Зөвлөлөөс гаргасан зөвлөмжид GDPR-ийн үйлчлэх цар хүрээг ерөнхий тодорхойлсон нь хууль тогтоогчийн дээрх хэм хэмжээг аль болох өргөн хүрээнд тайлбарлан хэрэглэх боломж олгох гэсэн хүсэл зоригийн илэрхийлэл юм³⁴ гэсэн байна.

GDPR-ийн үйлчлэх цар хүрээг тодорхойлохын өмнө хувийн мэдээлэл боловсруулагч болон хувийн мэдээлэл хариуцагч гэсэн ойлголтуудыг тодорхойлох шаардлагатай. GDPR-ийн 4.7 дугаар зүйлд тодорхойлсноор хувийн мэдээлэл хариуцагч гэдэг нь хувийн мэдээллийг боловсруулах зорилго болон арга хэрэгслийг тодорхойлж буй хувь хүн, хуулийн этгээд, төрийн байгууллага, агентлагийг хэлнэ гэж заажээ. Харин GDPR-ийн 4.8-д хувийн мэдээлэл боловсруулагч гэдгийг хувийн мэдээлэл хариуцагчийн нэрийн өмнөөс боловсруулалт хийж буй этгээдийг хэлнэ гэж тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, хувийн мэдээлэл хянагч гэдэг нь хувийн мэдээлэл боловсруулахтай холбоотой шийдвэр гаргаж буй этгээд, харин боловсруулагч гэдэг нь боловсруулах ажиллагааг гүйцэтгэж буй этгээдийг хэлнэ гэж ойлгож болно.

GDPR-ийн 3.1 болон 3.2 дугаар зүйлийн дараах шалгууруудын аль нэгийг хангасан тохиолдолд GDPR-ийн үйлчлэх цар хүрээнд багтана гэж үзнэ:

- (i) үйл ажиллагаа явуулж буй газрын шалгуур буюу *establishment test*;
- (ii) ямар этгээдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж буй шалгуур буюу *targeting test*.

³⁴ Guidelines 3/2018 on the territorial scope of the GDPR (Article 3), The European Data Protection Board, 4 дэх тал https://edpb.europa.eu/sites/edpb/files/files/file1/edpb_guidelines_3_2018_territorial_scope_after_public_consultation_en_0.pdf

Европын Холбооны нутаг дэвсгэрт хувийн мэдээлэл боловсруулах ажиллагаа хийгдэх эсэхээс үл хамааран тухайн хувийн мэдээлэл боловсруулагч болон хариуцагч нь Европын Холбоонд явуулж буй тогтвортой үйл ажиллагааны зохион байгуулалттай нь холбоотойгоор хувийн мэдээллийг боловсруулах ажиллагаа хийгдэж байгаа тохиолдолд үйл ажиллагаа явуулж буй газрын шалгуурыг хангана гэж үзнэ³⁵. Гэвч тухайн хувийн мэдээлэл боловсруулагч болон хариуцагч нь зайлшгүй Европын Холбооны аль нэг улсад бүртгэгдсэн, үүсгэн байгуулагдсан байхыг шаардахгүй. Харин дээрх шалгуурыг хангаж буй эсэхийг тодорхойлохдоо тухайн хувийн мэдээлэл хариуцагч болон боловсруулагчид ямар нэгэн байдлаар Европын Холбоонд тогтвортой үйл ажиллагаа явуулах зохион байгуулалтын хэлбэр байгаа эсэх, мөн хувийн мэдээлэл боловсруулах ажиллагаа нь уг зохион байгуулалтын хэлбэртэй нь уялдаа холбоотой эсэхийг тодруулна.

Түүнчлэн, хувийн мэдээлэл хариуцагч нь Европын Холбооны нутагт үйл ажиллагаа явуулдаг бол хувийн мэдээллийг боловсруулах ажиллагаа хаана явагдаж байгаагаас үл хамааран GDPR үйлчилнэ. Жишээлбэл, Стокхолмд удирдах газар нь байрладаг эмийн үйлдвэрлэгч компани явуулж буй бүхий л клиникийн туршилтын мэдээллүүдээ (ө.х хувийн мэдээлэл) Сингапур Улс дахь салбартаа боловсруулдаг. Энэ тохиолдолд хэдийгээр мэдээлэл боловсруулах үйл ажиллагаа нь Европын Холбооноос гадна явагдаж байгаа ч Европын холбооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг хувийн мэдээлэл хариуцагчийн өгсөн зааварчилгааны дагуу Европын Холбоонд хийгдэж буй үйл ажиллагаатай нь холбоотойгоор хувийн мэдээллийг боловсруулж байгаа тул мөн GDPR үйлчилнэ гэж үзнэ³⁶.

Харин ямар этгээдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж буй шалгуур нь Европын Холбоонд байрладаггүй хувийн мэдээлэл боловсруулагч болон хариуцагч нарт GDPR үйлчлэх нөхцөлийг тодорхойлсон байдаг. GDPR-ийн 3.2-т заасны дагуу Европын Холбоонд байрладаггүй хувийн мэдээлэл боловсруулагч болон хариуцагч нар нь Европын Холбоонд байгаа хувийн мэдээллийн эзний мэдээллийг доорх үйл ажиллагаатай холбоотойгоор цуглуулсан бол GDPR нь тэдгээрт үйлчилнэ. Үүнд:

- (i) хувь хүнээс төлбөр авах шаардлагатай эсэхээс үл хамааран Европын Холбоонд байгаа хувь хүмүүст бараа, үйлчилгээ үзүүлдэг; эсхүл

³⁵ GDPR-ийн 3.1 дүгээр зүйл.

³⁶ Guidelines 3/2018 on the territorial scope of the GDPR (Article 3), The European Data Protection Board, 9 дэх тал https://edpb.europa.eu/sites/edpb/files/files/file1/edpb_guidelines_3_2018_territorial_scope_after_public_consultation_en_0.pdf

- (ii) Европын Холбооны нутаг дэвсгэр дээр тухайн хувь хүмүүсийн үйлдлийн шинж чанарыг хянах зорилготой.

Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж ч дээрх шалгуурыг хангаж байвал GDPR-т заасан зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэгтэй этгээд болохоор байна. Гэвч зөвхөн тухайн хувийн мэдээлэл боловсруулагч, хянагчийн вэбсайт болон цахим хаягийг Европын Холбооноос үзэх боломжтой байх нь Европын Холбоонд байгаа хувь хүмүүст үйл ажиллагаа үзүүлэхээр “чиглэсэн” гэсэн шаардлагад нийцсэн гэж үзэхэд хангалтгүй. Харин Европын Холбооны нэг буюу түүнээс дээш тооны гишүүн улсуудын мөнгөн тэмдэгтээр гүйлгээ хийх боломжтой, эсхүл тэдгээрийн хэлээр үйлчилгээ үзүүлдэг, эсхүл Европын Холбоонд байрлалтай өөрийн үйлчлүүлэгчдээ иш татан дурдсан байх зэрэг нь тухайн этгээд Европын Холбоонд байгаа хувь хүмүүст чиглэсэн үйл ажиллагаа явуулах зорилготой гэж үзэх үндэслэл болж болно³⁷.

Тэрчлэн, Европын Холбоонд байгаа хувь хүмүүсийн мэдээллийг цуглуулж буй нь өөрийнх нь үзүүлж буй бараа, үйлчилгээтэй холбоотой байх ёстой. Жишээлбэл, Европын улсад амарч буй өөрийн ажилчны хувийн мэдээллийг хүний нөөцийн бодлого боловсруулахын тулд цуглуулах, хянах явдал нь GDPR-ийн цар хүрээнд хамаарахгүй юм. Европын Холбоонд байрлаж буй хувь хүн гэдэгт заавал Европын Холбооны гишүүн орны иргэншилтэй иргэд байхыг шаардахгүй. Дээрх нөхцөл байдлаас харвал, GDPR-ийн үйлчлэх цар хүрээ нь зөвхөн Европын Холбооны улс оронд бүртгэлтэй, тэнд үйл ажиллагаа явуулж буй этгээдүүдээр хязгаарлагдахгүй, харьцангуй өргөн хүрээг хамарсан байна.

(Б) ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ, ТҮҮНИЙГ БОЛОВСРУУЛАХ

GDPR-ийн 4 дүгээр зүйлд хувийн мэдээлэл гэдгийг “хувь хүнийг тодорхойлох, эсхүл тодорхойлж болохуйц аливаа мэдээллийг хэлэх бөгөөд тухайн хувь хүнийг тодорхойлж болохуйц мэдээлэл гэдэгт нэр, дахин давтагдашгүй дугаар, байршлын мэдээлэл, цахим тодорхойлогч мэдээлэл, эсхүл тухайн хувь хүний бие махбод, физиологи, генетик, оюун санаа, эдийн засаг, соёл болон нийгмийн нөхцөл байдалтай холбоотой мэдээллийг хэлнэ” гэж тодорхойлжээ. Европын Холбооны Хувийн Мэдээллийг Хамгаалах Зөвлөлөөс дээрх тодорхойлолтыг тайлбарлахдаа доорх үндсэн ойлголтыг авч үзэх шаардлагатай гэсэн байдаг. Үүнд:

- (i) хувь хүнтэй холбоотой аливаа мэдээлэл байх;

³⁷ GDPR-ийн Recitals (23). <https://gdpr-info.eu/recitals/no-23/>

(i) хувь хүнийг тодорхойлох, эсхүл тодорхойлж болохуйц мэдээлэл байх³⁸.

Нэн тэргүүнд, хувийн мэдээлэл нь зөвхөн хувь хүний мэдээлэл байна. Өөрөөр хэлбэл, хуулийн этгээд, аливаа төрийн байгууллагын мэдээллийг боловсруулахтай холбогдох харилцаанд GDPR үйлчлэхгүй. Харин аливаа мэдээлэл гэдэгт ямар нэгэн хатуу форматын шаардлага тавихгүй бөгөөд хувь хүний тухай “объектив” мэдээлэл буюу өндөр, нас гэх мэт мэдээлэл, эсхүл “субъектив” мэдээлэл буюу тухайн хувь хүний ажлын байр, хэрэглээний тухай мэдээллийн аль аль нь хамаарна. Мөн түүнчлэн, тухайн мэдээлэл нь зураг, бичлэг, тоо, график ямар ч хэлбэрээр илэрхийлэгдсэн байж болно. Жишээлбэл, гэр бүлийнхээ зургийг сэтгэл зүйчийн эмчилгээтэй холбогдуулан хүүхэд зурсан байвал тэр зураг нь тухайн хүүхдийн оюун санааны байдлыг илэрхийлж буй хувийн мэдээлэл болно³⁹.

Харин тухайн хүнийг тодорхойлох, тодорхойлж болох мэдээлэл гэдэгт тухайн хүний нэр, газар зүйн байршил, генетикийн мэдээлэл, цахим тодорхойлогч зэрэг хэд хэдэн төрлийн хувийн мэдээлэл хамаарч болохоор заажээ. Цахим тодорхойлогч гэдэгт харин тухайн хувь хүний IP хаяг, cookies⁴⁰ буюу вэбсайтад зочилсон хүний үйлдлийг хадгалж үлдээсэн мэдээлэл (хэзээ нэвтэрсэн, ямар мэдээлэл дээр дарсан тухай мэдээлэл, оруулсан нууц үг, кредит картын мэдээлэл гэх мэт) зэрэг хамаарна.

Зөвхөн өөрт байгаа мэдээлэл, жишээлбэл хэн нэг хүний хаяг болон нэрийг ашиглаад тухайн этгээдийг тодорхойлох боломжтой бол тухайн хүнийг “шууд” тодорхойлох хувийн мэдээлэл, харин өөрт байгаа хувийн мэдээлэл нь тухайн хүнийг шууд тодорхойлоход хангалттай биш боловч гуравдагч этгээдэд байгаа мэдээлэлтэй нэгтгэснээр уг хүнийг тодорхойлох боломжтой байвал хувь хүнийг шууд бус тодорхойлох хувийн мэдээлэл гэж үзнэ. Жишээлбэл, зөвхөн машины дугаарыг ашиглан тухайн хүнийг тодорхойлох боломжгүй ч цагдаа, төрийн байгууллагын бүртгэлийн мэдээлэлтэй тулгаснаар тухайн хүнийг тодорхойлж болох тул энэ нь шууд бус тодорхойлох хувийн мэдээлэл болно.

Хувийн мэдээллийг боловсруулах гэдэг нь хүн, эсхүл автоматжуулсан арга хэрэгслийн тусламжтайгаар хувийн мэдээллийг цуглуулах, бүртгэх, ангилах, бүтцэд оруулах, хадгалах, өөрчлөх, хандах, ашиглах, дамжуулах, устгах, эсхүл нэгтгэх, хязгаарлах, харьцуулах зэрэг байдлаар ил болгох ажиллагааг хэлнэ гэж GDPR-ийн 4 дүгээр зүйлд тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, боловсруулсан гэж

³⁸ “What is considered personal data under the EU GDPR”, <https://gdpr.eu/eu-gdpr-personal-data/>

³⁹ “What is considered personal data under the EU GDPR”, <https://gdpr.eu/eu-gdpr-personal-data/>

⁴⁰ GDPR-ийн Recitals (30), <https://gdpr.eu/recital-30-online-identifiers-for-profiling-and-identification/>

тооцогдохын тулд заавал анализ, тодорхой дүгнэлт хийсэн байх албагүй бөгөөд зөвхөн цуглуулах үйлдэл хүртэл хувийн мэдээллийг боловсруулсан гэдэгт хамаарахаар байна. Хувийн мэдээллийг аливаа этгээд боловсруулж байгаа бол GDPR-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу зүй ёсоор боловсруулсан байх ёстой. Ийнхүү зүй ёсоор боловсруулсан гэж үзэхийн тулд доорх шаардлагуудын аль нэгийг хангасан байна:

- (i) хувийн мэдээллийн эзэн зөвшөөрөл өгсөн;
- (ii) хувийн мэдээллийг боловсруулах нь мэдээллийн эзний оролцож буй аливаа гэрээний хэрэгжилт, биелэлтэд шаардлагатай эсхүл мэдээллийн эзний аливаа гэрээний харилцаанд орохын өмнө нь боловсруулах шаардлагатай;
- (iii) хууль тогтоомжийн дагуу хувийн мэдээллийг боловсруулах үүрэгтэй болсон (шүүхийн шийдвэрээр даалгасан, татвар төлөхтэй холбоотой асуудал);
- (iv) зөвшөөрөл өгөх боломжгүй байгаа хувь хүний мэдээллийг түүний, эсхүл бусад этгээдийн нэн чухал ашиг сонирхлыг хамгаалахын тулд боловсруулах шаардлагатай (эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэхийн тулд);
- (v) хувийн мэдээллийг боловсруулах нь нийтийн ашиг сонирхлын төлөө хийж буй үйлдэл, эсхүл захиргааны байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлж буй үйлдэлд шаардлагатай;
- (vi) хууль ёсны ашиг сонирхлын үүднээс хувийн мэдээллийг боловсруулах шаардлагатай. Гэвч тухайн нөхцөл байдалд хувь хүний үндсэн эрх, ашиг сонирхлыг хамгаалах асуудал нь боловсруулж буй этгээдийн хууль ёсны ашиг сонирхлоос дээгүүр тооцогдохоор байвал, ялангуяа хувийн мэдээллийн эзэн хүүхэд байх тохиолдолд хамаарахгүй.

Дээрх зохицуулалтаас үзвэл, хувийн мэдээллийг зүй ёсоор боловсруулсан гэж үзэхийн тулд нэг бол тухайн хувь хүнээс зөвшөөрөл авсан байх, эсхүл хууль болон бусад зайлшгүй шаардлагатай нөхцөл байдлын үед зөвшөөрөл авахгүйгээр хувийн мэдээллийг боловсруулж болохоор байна.

GDPR-ийн 6 дугаар зүйлд зааснаас гадна 9 дүгээр зүйлд хувь хүний “эмзэг” мэдээлэл буюу тухайн хүний үндэс угсаа, улс төрийн үзэл баримтлал, шашин шүтлэг, гүн ухааны итгэл үнэмшил, үйлдвэрчний эвлэлийн гишүүнчлэл, генетикийн болон биометрийн мэдээлэл, эрүүл мэндийн мэдээлэл, бэлгийн чиг хандлага болон бэлгийн амьдралын талаарх мэдээллийг боловсруулахад тусгай зохицуулалтыг тусгасан байдаг. Дээрх хувийн эмзэг мэдээллүүдийн тусгай

онцлогоос хамаарч зөвхөн 6 дугаар зүйлд зааснаас гадна бусад нөхцөл байдал хангагдсан тохиолдолд зөвшөөрөлгүйгээр боловсруулах боломжтой байхаар зохицуулжээ. Жишээлбэл:

- (i) улс төр, философи, шашин, үйлдвэрчний эвлэлийн чиг үүрэг бүхий холбоо, сан зэрэг ашгийн төлөө бус байгууллага нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд өөрсдийн гишүүд болон байнгын харилцаатай байдаг этгээдүүдийн хувийн мэдээллийг гадагш задруулалгүйгээр боловсруулах;
- (ii) хувийн мэдээллийн эзэн өөрөө олон нийтэд нээлттэй ил болгосон мэдээллийг боловсруулах;
- (iii) боловсруулах нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад шаардлагатай;
- (iv) урьдчилан сэргийлэх, эсхүл хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулах, өвчний онош тогтоох, эрүүл мэнд, эсхүл нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай;
- (v) нийтийн эрүүл мэнд, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд шаардлагатай;
- (vi) нийтийн ашиг сонирхол, шинжлэх ухаан, түүх, статистикийн судалгаа явуулахад шаардлагатай бол хувийн мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр боловсруулж болно.

GDPR-ийн 6 болон 9 дүгээр зүйлийн аль алинд нь хувь хүнээс зөвшөөрөл авсан тохиолдолд хувийн мэдээллийг боловсруулж болно гэж заасан байдаг. Тэгвэл чухам хувь хүний "зөвшөөрөл" зүй ёсоор авагдсан эсэх нь мөн нарийн зохицуулалттай бөгөөд үүнийг 7 дугаар зүйлд тодорхойлсон байдаг. Зөвшөөрлийг тухайн хувийн мэдээллийн эзэн нь аливаа дарамт, шахалтгүйгээр, чөлөөтэй өгсөн байх шаардлагатай бөгөөд хэрэв бичгээр зөвшөөрөл өгсөн бол тэр нь тодорхой, энгийн үгээр илэрхийлэгдсэн, ойлгомжтой үг хэллэгтэй байх шаардлагатай. Жишээлбэл, аливаа вэбсайт хувийн мэдээллийг боловсруулах тухай зөвшөөрлийг нэвтэрсэн хүмүүсээс авахаар бол аль хэдийн өмнө нь дугуйлсан цонхоор зөвшөөрөл авч болохгүй. Тэрчлэн, үйлдэл хийхгүй байх буюу зөвхөн хувийн мэдээллийг цуглуулж байгаа гэдгээ сануулсан бичиг үзүүлсэн боловч тухайн хүнийг идэвхтэй үйлдэл хийж зөвшөөрөхийг шаарддаггүй бол зөвшөөрөл авсанд тооцогдохгүй. Хэд хэдэн өөр зорилгоор хувийн мэдээллийг боловсруулж байгаа бол мөн зорилго тус бүртээ хандсан зөвшөөрлийг хувь хүнээс авах шаардлагатай⁴¹.

⁴¹ GDPR-ийн Recital (32), <https://gdpr.eu/Recital-32-Conditions-for-consent/>

(B) “RIGHT TO BE FORGOTTEN” БУЮУ МАРТАГДАХ ЭРХ

GDPR-г тусгасан бас нэгэн онцлог зохицуулалт нь *right to be forgotten* буюу мартагдах эрх юм. GDPR-ийн 17 дугаар зүйлд заасны дагуу доорх тохиолдолд хувийн мэдээллийн эзэн нь өөрийн хувийн мэдээллийг устгуулахаар шаардах эрхтэй бөгөөд хувийн мэдээлэл хариуцагч нь тухайн мэдээллийг устгах үүрэгтэй болно:

- (i) хувь хүн өөрийн өгсөн зөвшөөрлийг цуцалсан;
- (ii) тухайн хувийн мэдээллийг цуглуулсан, эсхүл боловсруулах болсон зорилго, шалтгааныг биелүүлэхэд тухайн хувийн мэдээлэл шаардлагагүй болсон;
- (iii) хувийн мэдээллийг зөвшөөрөгдсөн хууль ёсны ашиг сонирхлынхоо хүрээнд боловсруулж байсан боловч хувийн мэдээллийн эзэн зөвшөөрөл өгөхөөс татгалзсан, уг татгалзлыг үгүйсгэх хариу хууль ёсны ашиг сонирхол байхгүй байвал;
- (iv) хууль зөрчиж хувийн мэдээллийг боловсруулсан;
- (v) холбогдох хуулийн дагуу хувийн мэдээллийг устгах үүрэгтэй болсон;
- (vi) хүүхдийн хувийн мэдээллийг харилцах үйлчилгээний хүрээнд цуглуулсан бол.

Гэхдээ дээрх тохиолдол болгонд хувийн мэдээллийг автоматаар устгах үүрэг үүсэхгүй бөгөөд тухайн хувийн мэдээллийг боловсруулах ажиллагаа нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хүрээнд, эсхүл хууль, шүүхийн шийдвэрийн дагуу боловсруулж байгаа, нийтийн ашиг сонирхлын төлөө шинжлэх ухааны судалгаанд ашиглагдаж байгаа зэрэг тохиолдлуудад мэдээлэл боловсруулагч, хариуцагч нь устгах үүрэг хүлээхгүй. Цахим ертөнцөд мартагдах эрхийг бодитойгоор хэрэгжүүлэхийн тулд тухайн хувийн мэдээлэл боловсруулагч, хариуцагч нь устгагдсан хувийн мэдээлэл, түүнтэй холбоотой линк, хуулбар зэргийг өөрийн боломжит хэмжээнд мөн устгах үүрэг хүлээнэ⁴².

2014 онд технологийн томоохон компани Гүүгд холбогдох хэргийг Европын Холбооны Шүүхээс шийдвэрлэхдээ тухайн хувийн мэдээллийн эзэн нь Гүүгл хайлтын илэрцүүдээс өөрт хамаарах дутуу, ач холбогдлоо алдсан, хуучин мэдээлэл рүү чиглүүлсэн холбоосыг устгуулах эрхтэй гэж шийдвэрлэсэн юм⁴³.

⁴² GDPR-ийн Recital (66) <https://gdpr.eu/Recital-66-Right-to-be-forgotten/>

⁴³ Google Spain SL, Google Inc.-ийн эсрэг Agencia Española de Protección de Datos (AEPD) болон Mario Costeja González, Европын Холбооны шүүхийн шийдвэр, 2014 оны 5 дугаар сарын 13-ны өдөр <http://curia.europa.eu/juris/document/document.jsf?text=&docid=152065&pageIndex=0&doclang=EN&mode=req&dir=&occ=first&part=1&cid=305802>

Энэхүү хэргийн хүрээнд Испанийн иргэн Марио Гонзалес өөрийн байшинг дуудлага худалдаанд албадан оруулах 1998 оны зарын илэрц рүү хандсан холбоосыг устгуулах хүсэлт тавьсан байдаг. Нийгмийн даатгалын өрийг нь барагдуулахаар албадан дуудлага худалдаанд оруулсан уг нөхцөл байдал нь нэгэнт шийдвэрлэгдсэн бөгөөд өөрийнх нь нэрийг Гүүглээс хайх тутамд энэ илэрц гарч ирж байгаа нь түүний амьдралд сөргөөр нөлөөлж байна гэж тэрээр маргажээ. Европын Холбооны Шүүхээс Испанийн иргэний талд шийдвэр гарсан бөгөөд Гүүгл дээрх мэдээлэл рүү чиглүүлсэн холбоосыг устгах үүрэгтэй болсон юм.

Гүүгл хайлтын илэрцүүд нь олон жилийн турш хэвээрээ хадгалагдаж үлддэг тул дээрх хэргийн адил урт хугацааны өмнө болсон үйл явдал, эсхүл хэн нэгэн худал гүтгэлэгт өртөж байсан бол тэдгээрийн хувийн амьдралд энэхүү хуучин, буруу, худал мэдээллүүд нь сөргөөр нөлөөлөх магадлалтай. Иймд Европын Холбооны Шүүхээс ийнхүү дээрх илэрцүүд рүү хандах холбоосыг хувийн мэдээллийн эзэн устгуулахаар шаардах эрхтэй гэж үзжээ. Гэвч саяхан 2019 онд дахин Европын Холбооны Шүүхээс Гүүгл компанитай холбогдох мартагдах эрхийн тухай хэргийг шийдвэрлэсэн бөгөөд GDPR-аар хүлээсэн үүргийнхээ дагуу хувийн мэдээллийг устгах үүрэг нь зөвхөн Европын Холбоон дахь хайлтын илэрцүүдийг устгахаар хязгаарлагдана гэж шүүхээс дүгнэжээ⁴⁴. Өөрөөр хэлбэл, Монгол Улсаас хийж буй хандалтын илэрцийг Гүүгл заавал устгах үүрэггүй болсон юм.

GDPR-ийн хувьд үүргээ зөрчсөн тохиолдолд торгуулийн хэмжээ өндөр байдаг. Торгуулийг Европын Холбооны гишүүн улсууд оноох бөгөөд зөрчлийн шинж чанараас хамаарч (i) 10 сая еврогоос 20 сая евро хүртэлх үнийн дүнгээр торгох; эсхүл (ii) тухайн зөрчил гаргасан этгээдийн дэлхийн хэмжээнд олж буй жилийн орлогын 2-4 хувьтай тэнцэх хэмжээний аль өндөр дүнгээр нь торгоно.

GDPR нь дэлхий нийтийн хэмжээнд жишиг эрх зүйн хэм хэмжээ гэж тооцогддог ч өргөн үйлчлэх цар хүрээ, торгуулийн өндөр дүн зэрэг нь жижиг, дунд бизнес эрхлэгчдэд сөргөөр нөлөөлдөг гэсэн шүүмжлэлийг дагуулдаг. Гэсэн ч Австрали, Тайланд, Шинэ Зеланд, Өмнөд Солонгос зэрэг олон орон өөрсдийн хувийн мэдээллийг хамгаалах хуулийг GDPR дээр үндэслэн боловсруулсан байдаг. Манай улсын хувьд ч өмнө нь өргөн баригдсан Өгөгдөл хамгаалах хуулийн төсөлд GDPR-ийн ойлголт, зохицуулалтууд тусгагдсан байгааг үзвэл цаашид хувь хүний мэдээллийг хамгаалах зохистой эрх зүйн орчныг бүрдүүлэхийн тулд энэ баримт бичгийг судлах шаардлага зайлшгүй байгааг харуулж байна.

⁴⁴ Google LLC, successor in law to Google Inc.-ийн эсрэг Commission nationale de l'informatique et des libertés (CNIL), Европын Холбооны шүүхийн шийдвэр, 2019 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр
<http://curia.europa.eu/juris/document/document.jsf?docid=218105&doclang=EN>

2.4.2 Сингапур Улсын зохицуулалт

Сингапур Улс нь хувийн мэдээллийг хамгаалах, ашиглах, боловсруулахтай холбоотойгоор:

- (а) 2012 онд батлагдаж 2014 оноос хүчин төгөлдөр болсон “Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль”⁴⁵;
- (б) 1993 онд батлагдаж, 2007 онд нэмэлт өөрчлөлт оруулсан “Компьютерын халдагын тухай хууль”⁴⁶; болон
- (в) 2018 онд батлагдсан “Кибер аюулгүй байдлын тухай хууль”⁴⁷

ээрэг хэд хэдэн хуулийг дагаж мөрддөг. 2012 оны Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль нь хувь хүний мэдээллийг боловсруулах, хамгаалахтай холбоотой Сингапурын анхны хууль тогтоомж юм. Харин Компьютерын халдлагын тухай хууль нь кибер халдлага, цахим гэмт хэрэг, аюулгүй байдалтай холбоотой харилцааг, Кибер аюулгүй байдлын тухай хууль нь Сингапурын нэн чухал 11 салбарт хамаарах мэдээллийн дэд бүтцийг хамгаалахтай холбогдох харилцааг зохицуулдаг. Уг 11 салбар нь: Эрчим хүч, банк санхүү, эрүүл мэндийн үйлчилгээ, зорчигч тээврийн үйлчилгээ, харилцаа холбоо, медиа, батлан хамгаалах, яаралтай тусламжийн үйлчилгээ болон засгийн газар хамаарна гэж заажээ⁴⁸. Мөн түүнчлэн “ёс зүйтэй хакер” буюу этикал хакерууд дээрх нэн чухал салбарын мэдээлэлд халдах эрсдэлийг тодруулах зорилгоор халдаж болох бөгөөд энэ тохиолдолд зөвшөөрөл олгох ажиллагааг мөн уг хуульд зохицуулсан байдаг.

(А) ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

Хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 2 дугаар зүйл дэх нэр томъёоны тодорхойлолтыг үзвэл, хувийн мэдээлэл гэдэг нь өөрт байгаа мэдээллийг ашиглан, эсхүл гуравдагч этгээдэд буй мэдээлэлтэй нийлүүлснээр хувь хүнийг тодорхойлох боломжтой мэдээллийг хэлнэ гэж тодорхойлжээ. Уг тодорхойлолтод хувийн мэдээллийн төрлийг нэрлэж заагаагүй байх бөгөөд зөвхөн ерөнхий байдлаар тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, GDPR-ийн хувь хүнийг шууд болон шууд бус байдлаар тодорхойлох боломжтой мэдээллийг хувийн мэдээлэл гэж тодорхойлсон байна.

⁴⁵ Сингапур Улсын Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, <https://sso.agc.gov.sg/Act/PDPA2012>

⁴⁶ Сингапур Улсын Компьютерын халдлагын тухай хууль, <https://sso.agc.gov.sg/Act/CMA1993>

⁴⁷ Сингапур Улсын Кибер аюулгүй байдлын тухай хууль, <https://sso.agc.gov.sg/Acts-Supp/9-2018/>

⁴⁸ Сингапур Улсын Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйл

Хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн онцлог зохицуулалт нь Сингапурын хэмжээнд *Do Not Call Registry* буюу “Дуудлага хүлээн авахгүй утасны бүртгэл” хийх тухай зохицуулалт юм. Сингапурын үүрэн телефоны дугаартай хэрэглэгч нь аливаа компани, байгууллагуудаас маркетинг, зар сурталчилгааны дуудлага огт хүлээн авахыг хүсэхгүй байгаа тохиолдолд дээрх жагсаалтад бүртгүүлж болно гэж заажээ⁴⁹.

Тэрчлэн, Сингапурт үйл ажиллагаа явуулж, боловсруулсан мэдээллийг Сингапурын хувийн мэдээллийг хамгаалах эрх зүйн зохицуулалтаас доогуур хамгаалалт бүхий улс орон руу дамжуулахыг хориглосон байдаг. GDPR-ийн зохицуулалттай харьцуулбал Сингапурын Хувийн мэдээллийг хамгаалах тухай хуульд хувийн эмзэг мэдээллийн тухай тусгайлсан зохицуулалт агуулаагүй байдаг. Хууль зөрчсөн тохиолдолд хувь хүнийг 5,000-10,000 Сингапур доллароор торгох, эсхүл 12 сар хүртэлх хугацаанд хорих ял, харин хуулийн этгээдийг 50,000-100,000 Сингапур доллароор торгох зохицуулалттай байна.

Сингапур Улсын хувийн мэдээллийг хамгаалах болон мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах эрх зүйн зохицуулалтаас харахад, Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль нь GDPR-ийн зарим зохицуулалттай төстэй байгаа ч тухайн улсын онцлогт тохируулсан шинэ ойлголтуудыг мөн багтаажээ. Түүнчлэн, зөвхөн хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулиас гадна нэн чухал гэж тодорхойлсон салбар дахь цахим аюулгүй байдлыг хангах тухай асуудлыг тусгай хуулиар зохицуулж байгаа нь бусад улсуудаас онцлогтой байна.

⁴⁹ Сингапур Улсын Хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 36 дугаар зүйл

ГУРАВ. ҮР ДҮН

3.1 Дүгнэлт

Монгол Улсын хувь хүний нууц, мэдээллийг хамгаалахтай холбогдох суурь зохицуулалт нь Хувь хүний нууцын тухай хууль байх боловч уг хууль нь өнөө цагийн техник, технологийн хөгжилд нийцээгүй, хэт ерөнхий зохицуулалтыг агуулсан, хувь хүний нууц гэх ойлголтыг явцуу хүрээнд тодорхойлж, хувийн мэдээлэл гэх ойлголтыг тодорхойлолгүй орхигдуулсан гэх мэт олон сул талтай байна.

Хувь хүний нууцыг явцуу хүрээнд тодорхойлсноор иргэн шүүхээр өөрийн үндсэн эрх болох “нууцтай байх эрх”-ийг хангалттай хамгаалуулж чаддаггүй асуудал практикт тулгарч байна. Тэрчлэн, хувь хүний нууц болон хувийн мэдээллийг цуглуулах, хамгаалах, хадгалах, түүнд холбогдох иргэний эрхийг тодорхойлсон журам байхгүй тул хувийн хэвшлийн байгууллагуудад харьцангуй өөр өөр практик тогтжээ. Цаашлаад, нэгдсэн журам стандарт байхгүй тул хувь хүний нууц болон хувийн мэдээлэлтэй холбогдох ямарваа нэг маргаан үүсэх тохиолдолд иргэний эрх зөрчигдөөд л орхигдох аюултай байна. Иймээс энэхүү харилцааг зохицуулсан хууль Монгол Улсад шаардлагатай.

3.2 Санал, зөвлөмж

Бидний амьдралын салшгүй хэсэг болсон цахим технологийн улмаас тулгарч буй асуудлуудыг оновчтой зохицуулахын тулд хувь хүний нууц мэдээллээс гадна хувийн мэдээллийг дотоодын хууль тогтоомжид тодорхойлж, хамгаалах зайлшгүй шаардлагатай байна.

Удиртгал хэсгийн хоёр дахь гарчиг болох “Сэдвийн судлагдсан байдал” хэсэгт дурдсанчлан тус харилцаанд холбогдох хэд хэдэн хуулийн төсөл боловсруулагдаж байжээ. Иймд энэхүү хуулийн төслүүдэд холбогдуулан дэвшүүлэх хэд хэдэн санал, зөвлөмжийг доор дурдлаа.

“Цахим мэдээллийн аюулгүй байдлын тухай” болон “Мэдээллийн аюулгүй байдлын тухай” хуулийн төслүүдэд эдгээр хуулийн үйлчлэх хүрээг “цахим мэдээлэл” гэж хязгаарласан тул хэвлэмэл хэлбэрийн мэдээллийг хэрхэн хамгаалах талаарх асуудал зохицуулагдаагүй орхигджээ. “Мэдээллийн аюулгүй байдлын тухай” хуулийн төсөлд албан байгууллагуудыг (i) мэдээллийн сан төвлөрсөн, (ii) төрийн, (iii) онц чухал дэд бүтэц бүхий, (iv) мэдээллийн сүлжээ эзэмшиж буй байгууллага гэх мэтээр ангилан тус бүрийн үүрэг, хариуцлага

болон хэрэгжүүлэх ёстой арга хэмжээг тодорхойлж, мэдээллийн аюулгүй байдалд тавих хяналтыг Тагнуулын байгууллага болон Засгийн газар, УИХ-ын бүрэн эрх хэмээн заажээ. Хэдийгээр ингэж заасан боловч мэдээллийн эзэн болох хувь хүний эрх болон хувь хүний мэдээллийг цуглуулж, ашиглагч хувийн байгууллагын талаарх зохицуулалтыг мөн орхигдуулсан байна.

Харин “Өгөгдөл хамгаалах тухай” хуулийн төсөлд хувийн болон төрийн байгууллагууд нь иргэдийн мэдээллийг хамгаалах үүрэгтэй талаар ерөнхий зохицуулалтад тусгаж, мэдээллийг хэрхэн хамгаалах, хадгалах, цуглуулах талаар нарийвчлан зохицуулж, өгөгдлийн эзний мэдэх, алдааг засуулах, устгуулах, дамжуулах, татгалзах, автоматаар хувийн өгөгдөл боловсруулахтай холбоотой эрхийг тусгасан байна.

Гэвч уг хуулийн төсөл дэх өгөгдөл боловсруулах зөвшөөрөл өгөх тухай зохицуулалт нь цуглуулж байгаа өгөгдлөөс гадна өөр нэмэлт өгөгдөл авах шаардлагатай болгож байгаа нь ойлгомжгүй байна. Тодруулбал, уг хуулийн төслийн 6 дугаар зүйлд заасан зөвшөөрөлд зайлшгүй тусгах мэдээлэлд регистрийн дугаар, овог нэр, холбогдох хаяг, гарын үсэг, түүнтэй адилтгах илэрхийлэл гэх мэт нийт 9 зүйл багтжээ. Гэвч өгөгдлийг боловсруулж буй этгээд зөвхөн тухайн хүний нэр болон и-мэйл хаягийг цуглуулж байсан бол зөвшөөрөл авахын тулд дээр нь нэмээд регистрийн дугаар, хаягийг нь авах шаардлагатай болохоор байна. Зөвхөн зөвшөөрөл авах гэж цуглуулсан энэхүү нэмэлт мэдээллээ хадгалах, хамгаалах үүрэгтэй болох эсэх нь мөн тодорхойгүй байна. Түүнчлэн, дээрх бүхий л дурдах ёстой мэдээллийг багтаасан зөвшөөрлийн маягтыг аливаа хуулийн этгээд боловсруулсан ч зөвшөөрөл өгч буй энгийн иргэнд энэ нь хэр ойлгомжтой байж чадах эсэх нь эргэлзээтэй юм. Гэтэл бусад орны туршлагыг үзвэл зөвшөөрөл өгч буй мэдэгдэл нь ойлгомжтой, товч, тодорхой байх шаардлагатай байдаг.

Мөн уг хуулийн төсөлд мэдээллийг цуглуулж, боловсруулж буй зорилго бүрд хамаарах зөвшөөрлийг тус бүрд нь авах ёстой гэсэн шаардлагыг тусгаж өгөөгүй байгаа нь эрсдэлтэй юм. Жишээлбэл, нэг ерөнхий зөвшөөрлийн дор нэг байгууллага хувь хүнийг зөвхөн хэрэглэгчээр бүртгэх зорилгоор өгөгдлийг боловсруулсан ч уг зөвшөөрлөө ашиглаад тухайн хэрэглэгчийн худалдан авалтын мэдээллийг боловсруулах боломжтой гэж ойлгогдож байна.

Иймээс дээрх хуулийн төслүүдийн дутагдалтай талыг зассанаар дахин өргөн барих, эсхүл шинээр нэгдсэн зохицуулалтыг агуулсан хууль боловсруулах шаардлага зайлшгүй тавигдаж байна.

НОМ ЗҮЙ

А. Ном, сурах бичиг, гарын авлага

1. Глоб интернешнл төв “Монгол Улс – хэвлэл мэдээллийн эрх зүй (Онлайн, оффлайн орчин дахь хувь хүний нууц ба цахим эрх) Сургалтын гарын авлага” 2017 он http://globeinter.org.mn/images/upld/Toby_manual_2017mon.pdf

Б. Эрдэм, шинжилгээний өгүүлэл, илтгэл, хэлэлцүүлэг

2. Хуульч, судлаач Л.Галбаатар “Мэдээллийн аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалт” 2016 он <https://www.slideshare.net/galbaatar1/ss-62879383>
3. Б.Хонгорзул “Монгол Улсын Үндсэн хууль дахь хувийн нууцын эрхийг өргөн утгаар тайлбарлах нь” МУИС-ХЗС, Бакалаврын судалгааны ажил. 2016 он <http://legaldata.mn/b/147>
4. О.Мөнхсайхан “Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан Үндсэн эрхийн хүрээг тодорхойлох нь” эрдэм шинжилгээний өгүүлэл, Хүний эрх сэтгүүл 2016/01 <http://legaldata.mn/b/611>
5. Монголын хуульчдын холбоо “Мэдээллийн аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал” хэлэлцүүлэг, 2018 он
6. 北原宗律「日本の個人情報保護法の問題点」広島道大学リポジトリ・修道法学,29(2),224-201 (2007-02-28)

В. Хууль тогтоомж, хуулийн төсөл, хөтөлбөр

7. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
8. Хувь хүний нууцын тухай хууль, 1995 он
9. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, 2011 он
10. Улсын бүртгэлийн Ерөнхий хууль, 2018 он
11. Зээлийн мэдээллийн тухай хууль, 2011 он
12. ХЗДХС-ийн 2017 оны А/195 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, шалгах, шинжлэн үнэлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх журам”
13. Мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийн төсөл, 2016 он
14. Цахим мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийн төсөл, 2018 он
15. Өгөгдөл хамгаалах тухай хуулийн төсөл, 2018 он
16. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн “Төрийн байгууллагын цахим мэдээллийн санг “Үндэсний дата төв” УТҮГ-т шилжүүлэн байршуулах тухай” 146 дугаар тогтоол
17. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 141 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах Үндэсний хөтөлбөр”
18. Япон Улсын “Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль”

19. Герман Улсын “Холбооны Мэдээлэл хамгаалах тухай хууль”
20. Европын Холбооны “Өгөгдөл хамгаалах ерөнхий дүрэм”

Г. Шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол, ҮХЦ-ийн тогтоол

21. Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудын Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн магадлал дугаар 05 <http://shine.shuukh.mn/irgendavah/1368/view>
22. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн магадлал дугаар 113 <http://shine.shuukh.mn/irgendavah/1290/view>
23. Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 3908 дугаартай шийдвэрт дуу авианы бичлэг, харин 2016 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 3397 дугаартай шийдвэрт дүрс бичлэг нууцаар хийснийг нотлох баримтаар тус тус үнэлээгүй байна.
24. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 696 дугаар магадлал <http://shine.shuukh.mn/irgendavah/2137/view> болон Иргэний хэргийн хяналтын шатны шүүхийн 2017 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 130 дугаартай тогтоол <http://new.shuukh.mn/irgenhyanalt/2164/view>
25. Иргэний хэргийн хяналтын шатны шүүхийн 2014 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 157 дугаартай тогтоолоор Хаан банкны Төв аймаг дахь төв салбарын ажилтан хувийн ашиг сонирхлын үүднээс харилцагчийн зээлийн мэдээлэлтэй танилцсаныг ноцтой зөрчилд тооцон ажлаас халсан бөгөөд шүүхээс тус шийдвэр нь үндэслэлтэй гэж үзсэн байна. <http://www.shuukh.mn/irgenhyanalt/17/view>
26. Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 90 дүгээр цагаатгах тогтоол <http://new.shuukh.mn/eruuahan/45700/view>
27. Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 59 дугаар шийдвэр <http://new.shuukh.mn/eruuahan/40244/view>
28. Дархан-Уул аймгийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 39 дүгээр магадлал <http://new.shuukh.mn/erudavah/9910/view>
29. Улсын дээд шүүхийн 2020 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 435 дугаар тогтоол <http://new.shuukh.mn/eruuhanalt/2475/view>
30. Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 239 дугаар тогтоол <http://new.shuukh.mn/eruuhanalt/2420/view>
31. ҮХЦ-ийн 2014 оны 12 сарын 12-ны өдрийн 02 дугаартай тогтоол <https://www.legalinfo.mn/>

С. Цахим эх сурвалж, мэдээ


32. Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2020 оны эхний 9 дүгээр сард бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ <http://police.gov.mn/a/5330>
33. Privacyshield олон улсын байгууллагын судалгаа, “Mongolia – E-commerce”

- <https://www.privacyshield.gov/article?id=Mongolia-ECommerce>
34. Data protection regulations and international data flows: Implications for trade and development, UNCTAD-ийн судалгааны тайлан. 5 дахь тал,
https://unctad.org/system/files/official-document/dtlstict2016d1_en.pdf
 35. Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар “Монгол Улсын Нээлттэй Өгөгдлийн бэлэн байдлын үнэлгээ” судалгаа, УБ хот, 2018 он, http://www.smart.gov.mn/wp-content/uploads/2018/11/Mongolia_ODRA_report_Mon_2019.pdf
 36. Глоб интернешнл төв “Хувийн нууцын тухай хуулиуд”
<http://www.globeinter.org.mn/?cmd=Content&id=47&menuid=85>
 37. Аюулгүй хот” төслийн тухай
<https://ulaanbaatar.mn/Home/newsdetail?dataID=49191>
 38. Data and privacy unprotected in one third of countries, despite progress.
<https://unctad.org/news/data-and-privacy-unprotected-one-third-countries-despite-progress>
 39. 2020 онд GDPR-т гарч болох өөрчлөлтүүд <https://gdpr.eu/gdpr-in-2020/>
 40. Guidelines 3/2018 on the territorial scope of the GDPR (Article 3), The European Data Protection Board https://edpb.europa.eu/sites/edpb/files/files/file1/edpb_guidelines_3_2018_territorial_scope_after_public_consultation_en_0.pdf,
 41. “What is considered personal data under the EU GDPR”, <https://gdpr.eu/eu-gdpr-personal-data/>
 42. GDPR - Recitals (30) <https://gdpr.eu/recital-30-online-identifiers-for-profiling-and-identification/>
 43. GDPR - Recitals (32) <https://gdpr.eu/Recital-32-Conditions-for-consent/>
 44. GDPR - Recitals (66) <https://gdpr.eu/Recital-66-Right-to-be-forgotten/>
 45. Google Spain SL, Google Inc.-ийн эсрэг Agencia Española de Protección de Datos (AEPD) болон Mario Costeja González, Европын Холбооны шүүхийн шийдвэр, 2014 он 5 дугаар сарын 13-ны өдөр
<http://curia.europa.eu/juris/document/document.jsf?text=&docid=152065&pageIndex=0&doclang=EN&mode=req&dir=&occ=first&part=1&cid=305802>
 46. Google LLC, successor in law to Google Inc.-ийн эсрэг Commission nationale de l’informatique et des libertés (CNIL), Европын Холбооны шүүхийн шийдвэр, 2019 он 9 дүгээр сарын 24-ний өдөр
<http://curia.europa.eu/juris/document/document.jsf?docid=218105&doclang=EN>
 47. Сингапур Улсын Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль,
<https://sso.agc.gov.sg/Act/PDPA2012>
 48. Сингапур Улсын Компьютерын халдлагын тухай хууль,
<https://sso.agc.gov.sg/Act/CMA1993>
 49. Сингапур Улсын Кибер аюулгүй байдлын тухай хууль, <https://sso.agc.gov.sg/Acts-Supp/9-2018/>


ХАВСРААТ

Байгууллагуудаас авсан судалгааны үр дүн

ХЭРЭГЛЭГЧИЙН ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ЯМАР ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД ЦУГЛУУЛДАГ ВЭ?



ХЭРЭГЛЭГЧИЙН ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ, ЭСХҮЛ ТҮҮНИЙ БОЛОВСРУУЛАЛТАД СУУРИЛСАН МЭДЭЭЛЛИЙГ АЛИВАА ГУРАВДАГЧ ЭТГЭЭДЭД ШИЛЖҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ ЮУ?



ХЭРЭГЛЭГЧИЙН МЭДЭЭЛЛИЙГ ГУРАВДАГЧ ЭТГЭЭДЭД ШИЛЖҮҮЛЭХ ЭСЭХ ТАЛААР ХЭРЭГЛЭГЧЭЭС ЗӨВШӨӨРӨЛ АВДАГ УУ?

